Эмнэлгийн мэргэжилтэн бодит үзлэгийг ЗААВАЛ хийнэ. Үзлэг хийхдээ шаардлагатай тохиолдолд хүүхдийн эх болон гэр бүлийн гишүүдийг хамт байлцуулна. Хүүхэд эрүүл бол “Эрүүл” гэсэн хариултын өмнөх □ энэ нүдэнд √ тэмдгээр тэмдэглэнэ. Өвчтэй бол өөрчлөлт илэрсэн хэсэгт тэмдэглэнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл шүд - Эрүүл хүүхэд" хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, эрчимжүүлэх зорилгоор хүүхдийн Амны хөндийн эрүүл мэндийн асуудлуудыг багтаасан асуумжийг цогцоор оруулсан. Энэхүү асуумж нь мэргэжлийн шүдний эмч бус өрх, сумын эмч, сургуулийн эмч зааврын дагуу хараад тэмдэглэх боломжтойгоор оруулсан тус хүүхдийн шүдийг харж, маягтын дагуу тэмдэглэн, эмчилгээ, үйлчилгээ шаардлагтай хүүхдийг шүдний эмч, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад шуурхай явуулна.

Сүүн шүд унаагүй боловч байнгын шүд нь давхар ургасан эсэхийг сайтар тэмдэглэж мэргэжлийн эмчийн хяналтанд илгээнэ.

Байнгын 1-р их араа буюу 6-р шүд ургаж, буйлнаас цухуйж эхэлмэгц мэргэжлийн эмчид хандаж ховил битүүлэх эмчилгээ (ховилын ломбо) хийлгэх зайлшгүй шаардлагатай тул мэргэжлийн эмчийн хяналтанд илгээнэ.

Гэмтлийн улмаас шүд хөдөлгөөнд орсон хожуу үүсэх хүндрэлээс сэргийлж шүдний эмчид үзүүлж зөвлөгөө авах шаардлагатай

Холимог зуултын үед хүүхдийн сүүн ба байнгын шүдийг зураглалын шүд тус бүрт дараах байдлаар бичиж тэмдэглэнэ: Байнгын шүд: Ц, Л, А /цоорсон, ломбодсон, авсан/

Хүүхэд, өсвөр насныханд 8-18 насны хүүхдүүдэд ямар нэгэн хорт зуршилтай эмэх талаар асуумжийг заавал асууж, ажиглаж, үзлэг хийж бөглөнө.

Сэтгэцийн эмгэг өмнө нь оношлогдогдож байсан болон осол гэмтэлд өртөж байсан талаар асууж тэмдэглэнэ. Дараах тодорхойлолтыг баримтлана.

V. Ерөнхий дүгнэлт

Эмчийн ерөнхий дүгнэлтийг дараах байдлаар гаргана.
Үзлэгт хамрагдсан хүүхдэд ямар нэгэн эмгэг шинж болон өвчлөл илрээгүй тохиолдолд **Эрүүл** гэж дүгнэнэ.
Ямар нэгэн эмгэг болон өвчлөл илэрсэн тохиолдолд үндсэн өвчнийг сонгож дээрээс доош нь дараалуулах зарчмаар сонгож бичнэ. Үндсэн өвчин гэдэг нь хамгийн их оношлогоо, эмчилгээ шаардагдах өвчнийг хэлнэ.
Нэг хүүхдэд хэдэн ч өвчлөл бүртгэгдэж болох ба авсан арга хэмжээг доорх зааврын дагуу бүртгэсэн өвчлөл тус бүрд тодорхой зааж бичнэ.

- **Амьдралын хэв маягаа өөрчлөх (зөвлөгөө)**

2. **Хооллолт** **2. Идэвхитэй хөдөлгөөн** **3. Хорт зуршил** **4.Бусад**
   - Өрх, сумын ЭМТ-д хяналтанд авах **(кодоор)**
2. **3 хүртэлх сар** **2. 6 хүртэлх сар**
   - Өрх, сумын ЭМТ-д эмчилгээнд хамрагдах **(кодоор)**
2. Эмийн 2. Эмийн бус
   - Дээд шатлалын эмнэлэгт онош баталгаажуулах **(кодоор)**
2. Дүүргийн ЭМТ 2. АНЭ, БОЭТ3. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг 4. Хувь ЭМБ

   - Дээд шатлалын эмнэлэгт эмчилгээнд хамрагдах **(кодоор)**
2. Дүүргийн ЭМТ 2. АНЭ, БОЭТ3. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг 4. Хувь ЭМБ

Үзлэгт хамрагдсан хүүхдийг эрүүл мэндийг үзлэгийг үндэслэн эрүүл мэндийн 5 бүлэгт хамруулна. /Эрүүл мэндийн бүлгийг ойлголт, тодорхойлолт бүлгээс харна уу/

Маягтыг хөтлөх эмнэлгийн мэргэжилтэн: Өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч, сургуулийн эмч

Хадгалах хугацаа: Байнга

Маягтын нэр: НАСАНД ХҮРЭГЧДИЙН ЭРТ ИЛРҮҮЛЭГ ҮЗЛЭГИЙН МАЯГТ

Маягтын дугаар: ЭИМ-3

VI. Хүн ам зүйн ерөнхий мэдээлэл

Хүн ам зүйн ерөнхий мэдээллийг засаг захиргааны нэгжийн ангилал, кодын дагуу кодлож үнэн зөв, бүрэн гүйцэд бүртгэнэ. Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ.

Кодлох аргачлалыг ашиглан гэрлэлтийн байдлыг тэмдэглэнэ. Тусгаарласан гэдэгт гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй тусдаа амьдарч байгаа хүмүүсийг оруулна. Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч иргэний бүртгэл мэдээллийн төвд бүртгүүлж гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг батлуулаагүй гэж кодлоно.

Боловсролын түвшинг асуултын кодыг ашиглан тэмдэглэнэ.

VII. Эрүүл мэндийн ерөнхий мэдээлэл

Эрүүл мэндийн үзлэгийг хийхдээ эмч үйлчлүүлэгчийн биеийн жингийн индекс тооцоолоход шаардлагатай хэмжилтүүдийг хийж, тооцоолно

Биеийн жингийн индексийг тооцохдоо доорх томьёогоор олно.

$$\text{БЖИ} = \frac{\text{Жин}}{\text{Өндөр}^2} \times 100$$

Туранхай гэдэг нь - биеийн жингийн индекс 18.5-аас бага кг/м.кв байх

Хэвийн гэдэг нь - биеийн жингийн индекс 18.5-24 кг/м.кв байх

Илүүдэл жинтэй гэдэг нь - биеийн жингийн индекс 25-29 кг/м.кв байх

Тарган гэдэг нь - биеийн жингийн индекс 30 кг/м.кв-аас их байхыг байхыг хэлнэ.

Биеийн жингийн индексыг тооцоолж хүн амын артерийн даралт, чихрийн шижингийн эрсдлийн бүлгийг тодорхойлж, үзлэг хийх төлөвлөгөөг гаргана. Мөн халдвар бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн асуумжууд болох арх, тамхины хэрэглээ, жимс ногоо хэрэглэдэг эсэх, идэвхтэй хөдөлгөөн хийдэг эсэх талаар асуумжийг анхааралтай асууж, асуултын өмнөх дугаарыг дугуйлж, программ боловсруулалт хийнэ.

Амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг өрх, сумын эмч сургалтаар заагдсан удирдамжийн дагуу хийж одоо байгаа шүдний тоог бичиж, ☐ Эрүүл ☐ Эрүүл бус-ийн аль нэгийг тэмдэглэнэ.
Хэрэв эрүүл бус гэвэл: Буйлны үрэвсэл (шүдээ угаахад цус гардаг эсэх) ☐ Амны салстад шарх үүсдэг ☐ Авгддаг шүдэлбэр зүүдэг (хиймэл шүд: хуванцар, уян хуванцар) ☐ Шүдэлбэрийн таарамж сайн, дунд, муу (доогуур нь зурж тэмдэглэ) ☐ Авгддаггүй шүдэлбэр (гүүрэлсэн шүдэлбэр, бүрээс, шаазан бүрээс, имплант гэх мэт) доогуур нь зурж тэмдэглэнэ.
Бусад үзлэгийг удирдамжийн дагуу хийж маягтын харьяалагдах асуумжийн өмнөх дугаарыг дугуйлж тэмдэглэнэ.

ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ

VIII. Артерийн гипертензи

Насанд хүрэгсдийн артерийн гипертензийн үзлэгийг Эрүүл мэндийн сайдын 2018 оны 07 сарын 17-ны өдрийн А/286 дугаар тушаалаар батлагдсан эмнэлзүйн зааврын дагуу үзлэг, оношлогоог хийж бүртгэнэ.

Артерийн гипертензи эрт илрүүлгийн үзлэгийг өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн үзлэгийн эмч нар эмнэлгээр үйлчлүүлж буй 40-өөс дээш насны хүн амд хийнэ.

Артерийн даралт ихсэх эрсдэлтэй хүн амд 55-аас дээш насны эрэгтэй, 65-ас дээш насны эмэгтэйчүүдийг хамруулах ба мөн тамхи татдаг, удамшлын өвчинтэй, гиперхолестеринемитэй хүн амыг хамруулна.

Та сүүлийн 1 жилийн хугацаанд цусны даралтаа хэмжүүлсэн үү? асуугаад хэмжүүлсэн бол 1. Тийм, хэмжүүлээгүй гэж хариусан тохиолдолд 2.Үгүй хариултын өмнөх тоог дугуйлна.

Даралтын хэмжихдээ АГ-ийн илрүүлгийг баталгаажсан багажаар хийсэн олон удаагийн хэмжилт дээр үндэслэнэ. Хамгийн багадаа 2 удаагийн ирэлтээр, ирэлт бүрийн 2-3 удаагийн хэмжилтийн дунджаар АД-ын түвшинг тооцно.

Артерийн даралтаа хэмжүүлэхээс хамгийн багадаа 30 минутын өмнө хүнд зэргийн дасгал, хөдөлгөөн хийх, хэт идэх, кофе, цай, кока-кола уусан эсэхийг асууж, дүгнэлт гаргахдаа харгалзан үзнэ.

Өвчтөнд хэмжилт эхлэхийн өмнө дуу чимээгүй тасалгаанд хэдэн минут тайван суулгах ба артерийн даралтыг хэмжих явцад хэмжүүлж буй хүнтэй ярилцахыг хориглоно. Нуруугаа тэгш, урагш тонгойж гэдэс шахагдах байрлалд суулгахгүй, гарын бугалга ба зүрх ижил тувшинд байрласан байх ёстой. Гарын бугалга зүрхнээс дээш тувшинд байрлавал газрын татах хүчний нөлөөгөөр АД бага хэмжигддэг. Суудлын өндрийг тохируулан, хөлийн улаар шалан дээр бүтэн гишгүүлж суулгана. Артерийн даралтыг 1-2 минутын зайтайгаар, доод тал нь 2 удаа хэмжих ба даралтын түвшин зөрүү ихтэй байвал нэмэлт хэмжилтийг давтан хийнэ. Тарган, эсвэл туранхай хүнд том, жижиг манжетийг тааруулж, тохируулан хэрэглэх ба даралт буруу хэмжигдэх дараах үйлдлүүдийг анхаарна.

- Ханцуйгаа шамлах

- Хөлөө сандал, эсвэл ширээний хөндлөвч дээр тавих

- Бариу хувцас өмсөх (хоолойтой цамц/свитер)

- Алхаж, эсвэл дасгалын дараа цусны даралтыг шууд хэмжих

- Гараа тохойвчин дээр буруу байрлуулах

- Урагшаа тонгойх

- Тасалгаа хэтэрхий хүйтэн байх зэрэг нь артерийн даралтад нөлөөлдөг тул эдгээрийг зайлшгүй анхаарч, зөв хэмжилтийг хийнэ.

Цусны даралт хэмжилтийн үр дүнг дараах хүснэгтийн дагуу тэмдэглэнэ.

Түвшин	САД (мм.муб)	ДАД (мм.муб)
Хэвийн	<120	<80
Ихэссэн	120-129	<80
Артерийн гипертензи		
1-р зэрэг	130-139	80-89
2-р зэрэг	>140	>90

IX. Артерийн гипертензийн онош баталгаажилт ба кодлох аргачлал

Үр дүнгийн үзүүлэлт тооцохдоо үзлэгийн эмч үйлчлүүлэгчийн цусны даралтыг 3 удаа хэмжиж, хэрэв цусны даралтын хэмжээ сиастолын даралт (СД) 120-өөс бага, ДД 80-ээс бага байвал хэвийн, СД 130 буюу түүнээс их, ДД 80 буюу түүнээс их байвал дахин даралтаа хэмжүүлэхийг товлон артерийн гипертензи байж болзошгүй гэж тодорхойлно.

Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн давтан үзлэгийн үр дүнгийн тайлан

Артерийн гипертензи давтан үзлэгийн хэд хэдэн хэмжилтээр батлагдсан, эмчилгээ эхэлсэн үйлчлүүлэгчийн цусны даралт СД 130 буюу түүнээс их, ДД 80 буюу түүнээс их, нүдний уг дурандахад нүдний угт өөрчлөлт өгсөн байвал батлагдсан артерийн гипертензитэй гэж оношлоно.

Оношлогдсон тохиолдлыг шинээр бүртгэгдсэн өвчлөл гэж эрүүл мэндийн бүртгэл статистикийн програм хангамжид оруулан Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу тохирох кодыг тавина.

Даралт ихсэх өвчнийг I10-I15-аар кодлоно.

I10 Анхдагч даралт ихсэх өвчин

I11._ Зүрхний даралт ихсэх өвчин

I12._ Бөөрний даралт ихсэх өвчин

I13._ Зүрх ба бөөрний даралт ихсэх өвчин

I15._ Хоёрдогч даралт ихсэх өвчин

Даралт ихсэх өвчин ба зүрхний өвчин:

Хэрвээ зүрхний өвчин даралт ихсэх өвчний шалтгаант байвал I11._ Зүрхний даралт ихсэх өвчин гэж кодлоно. Жишээ нь: Зүрхний даралт ихсэх өвчин , кардиомегали I11.0

Хэрвээ зүрхний өвчин даралт ихсэх өвчний шалтгаант бус байвал тусад кодлоно. Атеросклероз зүрхний судасны өвчний шалтгаант байвал дараах байдлаар кодлоно.

Даралт ихсэх өвчин I25.1 I10

Бөөрний өвчний шалтгаант даралт ихсэх өвчин байвал I12._ кодлоно.

Зүрх ба бөөрний даралт ихсэх өвчин:

- хэрвээ I11._хамаарах зүрхний өвчин ба I12._ т хамаарах бөөрний өвчин хавсарсан байвал I13._ Зүрхний болон бөөрний даралт ихсэх өвчин гэж кодлоно.

- I11._ ба I13._ хамтад нь эсвэл I12._ ба I13. хамтад нь_ , эсвэл I11._ ба I12._ хамтад нь хэзээ ч кодлож болохгүйг анхаар.

Хоердогч даралт ихсэх өвчин

- Тодорхой өвчний үед хоёрдогчоор үүссэн даралт ихсэх өвчин I15._ Даралт ихсэх өвчнийг 2догчоор үүсгэж байгаа өвчин үндсэн оношоор, даралт ихсэх өвчнийг дагалдах оношоор кодлоно.

Жишээ нь: Бөөрний артерийн судасны нарийслаас үүдэлтэй даралт ихсэх өвчин I70.1 I15.0

1-р зэргийн артерийн гипертензи оношлогдсон тохиолдолд өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмчийн хяналтад авч, удирдамжийн дагуу эмчилгээг хийх ба Эмчийн дүгнэлт хэсэгт амвдралын хэв маягаа өөрчлөх, өрх, сумын ЭМТ-д хяналтад авах, эмчилгээнд хамруулсан эсэхийг ялган тэмдэглэгээг хийнэ.

X. Артерийн гипертензи, нарийн мэргэжлийн эмчид илгээх заалт

Дараах шинж тэмдэг илэрсэн болон нарийн шинжилгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд дээд шатлалын эмнэлэгт илгээж Эмчийн дүгнэлт хэсэгт бичиж тэмдэглэнэ.

- Гипертензийн хямрал (криз)
- Хоёрдогч АГ
- Онцгой тохиолдлууд
- Бай эрхтний гэмтлийг илрүүлэх: Зүрх, бөөр, нүдний уг харах, цусны судасны эмгэгийг илрүүлэх гэх мэт.

XI. Чихрийн шижин

Цусан дахь сахарын хэмжээ ихэссэн эсвэл чихрийн шижин өвчнөөр оношлогдож байсан эсэх: талаар асуумжаар өмнө нь чихрийн шижин оношлогдсон бол 1. **Тийм,** өмнө шинжилгээгээр чихрийн оношлогдоогүй болон цусан дахь сахарын хэмжээ хэвийн байдаг тохиолдолд 2. **Үгүй**, шинжилгээ оношлогоо хийлгэж байгаагүй, цусан дахь сахарын хэмжээ ихсэж байсан эсэх талаар мэдээлэлгүй тохиолдолд 3**. Мэдэхгүй** гэдгийн өмнөх дугаарыг дугуйлна. Өмнө нь чихрийн шижин оношлогдсон хяналтад байдаг хүнийг дараагийн үр дүнг бөглөх шаардлагагүй. Бусад тохиолдолд эхлээд эрсдлийг тодорхойлно.

Чихрийн шижингийн эрсдэлийн үнэлгээг АНУ-ын ЧШ-гийн холбоо (ADA)-ноос гаргасан ЧШ-гийн эрсдлийн шалгуураар 8 ба түүнээс дээш оноо бүхий эрсдэлтэй хүн амд өлөн үеийн глюкозыг түргэвчилсэн аргаар үнэлэн, 5.6 ммоль/л ба түүнээс дээш гарсан тохиолдолд ЧШ-гийн онош тодруулах шинжилгээнд илгээнэ.

Чихрийн шижингийн эрсдэл бүхий хүн ам:

- 35 ба түүнээс дээш насны хүн ам;
- Таргалалт ба биеийн жингийн илүүдэлтэй (БЖИ>25 кг/м^2, бүсэлхийн тойрог эрэгтэй >94см, эмэгтэй >80см);
- ЧШ-гийн удамшлын өгүүлэмжтэй (эцэг, эх, ах, эгч нь чихрийн шижинтэй);
- ЧШ-гийн эрсдлийн шалгуураар 8 ба түүнээс дээш оноо бүхий хүмүүс;
- Даралт ихсэлттэй буюу даралт бууруулах эм хэрэглэж буй;

- Зүрх судасны эмгэгтэй (зүрхний титэм судасны эмгэг, тархинд цус харвалт, захын судасны эмгэг);
- Бөөрний архаг эмгэгтэй;
- Жирэмсэн эмэгтэй (24-28 долоо хоногтой);

Чихрийн шижингийн эрсдлийн оноог Чихрийн шижингийн эрсдлийг тодорхойлох тусгай шалгуур хүснэгтийн дагуу тодорхойлно.

1	**Нас**	
	40-өөс доош	0
	40-49	1
	50-59	2
	60-аас дээш	3
2	**Хүйс**	
	Эрэгтэй	1
	Эмэгтэй	0
3	**Жирэмсэний ЧШ оношлогдож байсан эсэх**	
	Тийм	1
	Үгүй	0
4	**Эцэг, эх,ах, эгч, дүү ЧШ оношлогдож байсан эсэх**	
	Тийм	1
	Үгүй	0
5	**Артерийн даралт ихсэлт ба даралт бууруулах эм хэрэглэж буй эсэх**	
	Тийм	1
	Үгүй	0
6	**Өдөр бүр идэвхтэй дасгал хөдөлгөөн хийдэг эсэх**	
	Тийм	0
	Үгүй	1
7	**Биеийн жин хэвийн эсэх**	
	Тийм	0
	Үгүй	1
8	Нийт оноо	

Нийлбэр оноо:

Эрсдэл бага –Чихрийн шижингийн эрсдлийн оноо 4-оос бага байх;

Дунд зэргийн эрсдэлтэй- Чихрийн шижингийн эрсдлийн оноо 5-7 байх;

Өндөр эрсдэлтэй- Чихрийн шижингийн эрсдлийн оноо 8-аас дээш байх;

Цусны глюкозыг түргэвчилсэн (глюкометр) болон биохимийн гэсэн 2 аргаар тодорхойлж болно.

Үр дүнгийн үзүүлэлт

Хэвийн-түргэвчилсэн аргаар өлөн үед цусан дахь глюкозын хэмжээ 5.5-аас бага, биохимийн аргаар шинжилсэн үед 6.0-ээс бага байх;

Өлөн үеийн глюкозын өөрчлөлттэй - түргэвчилсэн аргаар өлөн үед глюкозын хэмжээ 6.0-ээс их, биохимийн аргаар үзэхэд 6.9-оос их байх;

Үр дүнгийн үзүүлэлтээр өлөн үеийн глюкозын өөрчлөлттэй эсвэл гипергликеми илэрсэн үед дараагийн шатлалд шилжүүлж цусны сийвэнд биохимийн аргаар глюкоз тодорхойлно.

Онош тавихдаа цусны глюкозын хэмжээг үндэслэн эмч дүгнэж Чихрийн шижин хэв шинж 2 онош батлагдсан эсэхийг дүгнэж тэмдэглэнэ.

1. Чихрийн шижин хэв шинж 2 өвчтэй
2. Чихрийн шижин хэв шинж 2 өвчингүй
3. Чихрийн шижин хэв шинж 2 байх сэжигтэй (Зөвхөн Глюкозын ачаалалтай сорил хийсний дараа тавигдана)

Өлөн үед, санамсаргүй тохиолдолд түргэвчилсэн аргаар болон биохимийн аргаар глюкоз үзэхэд глюкозын өөрчлөлттэй гарсан тохиолдолд оношийг батлах зорилгоор глюкозын ачаалалтай сорилыг удирдамж аргачлалын дагуу хийж маягтад тэмдэглэгээг хийнэ..

Оношийг лавлагаа шатлалын эмнэлэгт баталгаажуулж, батлагдсан тохиолдолд тэмдэглэж оношийг тавина.

Чихрийн шижин E10-E14 кодод хамаарах ба ангиалал, хүндрэлээс шалтгаалан дараах аргачлалын дагуу кодлоно.

- Хэрвээ олон хүндрэлтэй боловч аль нэг нь давамгайлсан тодорхойлогдоогүй бол олон хүндрэлтэй .7 гэж кодлоно.

ИҮХЧШӨ бөөрний , захын судас үхжил, катарактай хавсарсан
E11.7 ЧШӨ олон хүндрэлтэй
E11.2† Инсулинээс үл хамаарах ЧШӨ бөөрний хүндрэлтэй
N08.3* Гломерулонефрит
E11.5† Инсулинээс үл хамаарах ЧШӨ захын цусны эргэлтийн хүндрэлтэй
I79.2* Захын судасны ангипати
E11.3† Инсулинээс үл хамаарах ЧШӨ нүдний хүндрэлтэй
H28.0* ЧШӨ үеийн катаракт

- <u>Чихрийн шижин өвчний төрөл, хүндрэлүүд</u>
  - Хэв шинж I = Инсулинээс хамаарах ЧШӨ = ЧШӨ өсвөр насанд үүсдэг
  - Хэв шинж II = Инсулинээс үл хамаарах ЧШӨ = ЧШӨ насанд хүрсэн хойно үүсдэг
- Хүндрэлийг кодлохдоо дараах 4 дэгч тэмдэглэгээг тавина.

.0 Комтой
.1 Кетоацидозтай
.2 Бөөрний хүндрэлтэй
.3 Нүдний хүндрэлтэй
.4 Мэдрэлийн хүндрэлтэй
.5 Захын цусны эргэлтийн хүндрэлтэй
.6 Бусад тодорхой хүндрэлтэй
.7 Олон тооны хүндрэлтэй
.8 Тодорхойгүй хүндрэлтэй
.9 Хүндрэлгүй

Үйлчлүүлэгчийг дараагийн шатлалын эмчид илгээх заалт

- Шинээр оношлогдсон чихрийн шижинтэй үйлчлүүлэгчийг онош баталгаажуулах зорилгоор лавлагаа шатны эмнэлгийн дотоод шүүрэл судлаач эмч рүү илгээнэ.

- Метформин эмчилгээнд (хоногт 2000 мг) үр дүнгүй эсвэл бодисын солилцооны хямрал (шээсэнд кетон+) илэрсэн, мөн ЧШ-тэй жирэмсэн эмэгтэйг лавлагаа шатны дотоод шүүрэл судлаач эмч рүү илгээнэ.

- ЧШ-гийн архаг хүндрэлүүдийн эмнэлзүйн шинж илэрсэн тохиолдолд өрх, сум, тосгоны ЭМТ-өөс харьяа аймаг, дүүргийн ЭМТ-ийн нүд, зүрх, бөөр, мэдрэл, мэс засал зэрэг төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч рүү илгээнэ.

- Олон эрхтний хүндрэл хавсарсан тохиолдолд лавлагаа шатны (төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг) ЧШ-гийн хүндрэлээр мэргэшсэн багт (нүд, зүрх судас, бөөр, мэдрэл, судасны мэс засал, хөлний эмч) илгээнэ.

XII. Цусан дахь холестрины түвшин

Цусан дахь холестрины түвшинг өрх, сумын эрүүл мэндийн төвийн харьяаны 40-өөс дээш насны хүн амд хийнэ. Эрсдлийн бүлгийг толорхойлон эрсдэл өндөртэй хүмүүст тодорхойлох ба аргачлалын дагуу үзэж дүгнэлт, тэмдэглэгээг хийнэ.

XIII. Хөх, Умайн хүзүүний хавдар

Хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийг 30-60 насны эмэгтэйчүүдэд хийнэ. Үзлэгийг хөх, умайн хүзүүний хавдрыг илрүүлэх удирдамжийн дагуу хийж, үр дүнг тэмдэглэнэ. Нүдээр харах тэмтрэхэд хэвийн байна уу, Бэрсүү байна уу Бэлэгдсэн /хөдөлгөөн/ байдал Жүржийн хальсны шинж /арьсны шархлаа/ зангилаа Хөхний толгой цааш татагдсан Хөхний толгойноос шүүрэл гарах зэрэг шинж байгаа эсэхийг сайтар үзэж, үр дүнг тэмдэглэнэ.

Өөрчлөлт илэрсэн тохиолдолд лавлагаа шатлалын эмнэлэгт онош тодруулахаар илгээнэ.

XIV. Түрүү булчирхайн хавдрын илрүүлэг үзлэг

Түрүү булчирхайн хавдрын эрт илрүүлэг үзлэгийг 50 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдэд хийнэ. IPSS асуумжийг түрүү булчирхайн томролтой өвчтөнд илрэх шинж тэмдгийн үнэлэхэд ашиглана.

Гадагшлуулалт хямралын шинж							
1	**Шээсний дараа давсаг бүрэн сулрахгүй байх** Энэ мэдрэмж хэр олон тохиолдсон бэ?	0	1	2	3	4	5
2	**Шээс тасалдах** Шээс явцад тасалдаж, дахин шээс тохиолдол хэр олон тохиолдсон бэ?	0	1	2	3	4	5
3	**Шээс дусагнах эрчим султай гарах** Хэр олон тохиолдсон бэ?	0	1	2	3	4	5
4	**Дүлүүлж шээх** Шээж эхлэх үед дүлэх байдал хэр олон тохиолдож байсан бэ?	0	1	2	3	4	5
Хуримтлуулалт хямралын шинж							
5	**Шээсний давтамж** 2 цагийн дотор дахин шээх шаардлага хэр олон тохиолдсон бэ?	0	1	2	3	4	5
6	**Шээсээ барихад хэцүү болох** Хэр олон тохиолдсон бэ?	0	1	2	3	4	5
7	**Шөнийн шээлт**	Үгүй	1 удаа	2 удаа	3 удаа	4 удаа	5< удаа
	Унтахаар хэвтсэний дараа өглөө босох хүртэл хэдэн удаа босож шээдэг вэ?	0	1	2	3	4	5
	Ерөнхий IPSS						

- 7 асуулттай, асуулт бүр 6 хариултын хувилбартай
- Нийт 0-35 оноо байна
- Дүгнэхдээ:
- Нийлбэр оноо бага байх тусам түрүү булчирхайн эмгэгийн шинж тэмдэгийн илрэл бага байх ба эмийн эмчилгээний үр дүн сайн байна.

Шинж тэмдэг бага зэргийн илрэлтэй	**0-7 оноо**
Шинж тэмдэг дунд зэргийн илрэлтэй	8-19 оноо
Шинж тэмдэг хүнд зэргийн илрэлтэй	20-35 оноо

XV. Зүрхний цахилгаан бичлэг

Зүрхний цахилгаан бичлэгийг өрхийн эрүүл мэндийн төвийн харьяаны 40-өөс дээш насны хүн амд хийнэ.

Мобайл зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар үр дүн хэвийн гарсан тохиолдолд 1, өөрчлалттэй гарсан тохиолдолд хэвийн эсвэл эргэлзээтэй гэсэн үр дүнг дугуйлна. Үзлэгээр хэвийн бус оношлогдсон тохиолдолд хэм алдалт, ишемийн өөрчлөлт, бусад шинж тэмдгийн аль тохирохыг заавал тэмдэглэнэ.

Үзлэгээр хэвийн бус гарч ямар нэгэн онош тавих боломжгүй тохиолдолд **3. эргэлзээтэй** гэж тэмдэглэнэ.

Оношийн баталгаажилтийг хэвийн гэж дугуйлсан тохиолдолд **2. Эрүүл** тэмдэглэгээг хийнэ.

Хэвийн биш гээд хэм алдалт, ишемийн өөрчлөлт болон бусад өвчин оношлогдсон тохиолдолд **1. Өвчтэй** тэмдэглэгээг хийж оношийг Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу кодлож, сарын шуурхай мэдээлэлд өвчлөлийг бүртгэн бүртгэл статистикийн програм хангамжид бүртгэж мэдээлнэ.

Өвчний сэжигтэй гэдэг нь хэвийн бус боловч өрх, сумын эрүүл мэндийн төвд онош тавих боломжгүй тохиолдолд лавлагаа шатлалын эмнэлэгт онош тодруулахаар илгээнэ.

XVI. Хэт авиан (ЭХО)оношилгоо

Хэт авиан оношлогоог өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн үзлэгийн эмч нар эмнэлгээр үйлчлүүлж буй 40-өөс дээш насны хүн амд хийнэ.

Мобайл ЭХО – ны үр дүнгээр ямар нэгэн өөрчлөлтгүй тохиолдолд **1. Хэвийн** тэмдэглэгээг хийнэ. Үзлэгээр өөрчлөлт илэрсэн тохиолдолд **2. Хэвийн бус** тэмдэглэгээг хийнэ.

Хэвийн бус гэж тэмдэглэсэн тохиолдолд маягтад өгөгдсөн эрхтнүүдийн аль нэгд заавал тэмдэглэгээ хийгдсэн байх ба эсвэл хэд хэдэн эмгэг өөрчлөлт илэрч, тэмдэглэгдсэн байж болно.

Оношийн баталгаажилтийг хэвийн гэж дугуйлсан тохиолдолд **2. Эрүүл** тэмдэглэгээг хийнэ.

Хэвийн биш байвал оношлогдсон Өвчний олон улсын 10-р ангиллын дагуу кодлож, сарын шуурхай мэдээлэлд өвчлөлийг бүртгэн бүртгэл статистикийн програм хангамжид бүртгэж мэдээлнэ.

Өвчний сэжигтэй гэдэг нь хэвийн бус боловч өрх, сумын эрүүл мэндийн төвд онош тавих боломжгүй тохиолдолд лавлагаа шатлалын эмнэлэгт онош тодруулахаар илгээнэ.

Халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгээр дээрх шалтгаануудаас бусад өвчлөл илэрсэн эсэх гэсэн асуултад заавал хариултыг тэмдэглэх ба ямар нэгэн өвчлөл илрээгүй бол **2. Үгүй,** эмгэг илэрсэн тохиолдолд 1. Тийм гэдэг тэмдэглэгээг хийж, ямар өвчин, зовиур илэрсэн талаар тодорхой бичиж тэмдэглэнэ.

ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ

XVII. Сүрьеэ өвчний илрүүлэг үзлэг

Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нар 18-аас дээш насны хүн амд илрүүлэг үзлэг хийнэ. Сүрьеэгийн шинж тэмдэг ба зовиур, Сүрьеэгийн тархвар судлалын асуумжаар сэжигтэй шинж илрэхгүй байвал хэвийн гэж үзээд сүрьеэ өвчингүй гэсэн дүгнэлтэд хүрнэ.

Асуумжаас сэжигтэй тохиолдол илэрвэл цээжний рентген, цэрний шинжилгээг авах эсэхийг шийдвэрлэнэ.

Шаардлагатай тохиолдлуудад Цээжний рентген шинжилгээнд хамруулж, цаашид цэрний шинжилгээ өгөх эсэхийг шийдвэрлэнэ. Оношийг лавлагаа шатлалын эмнэлэгт илгээж баталгаажуулна.

В, С вирүст хепатит, Тэмбүүгийн эрт илрүүлэг үзлэгийг удирдамжийн дагуу хийж харгалзах хариу, дүгнэлтийн өмнөх тоог дугуйлж, програм хангамжид оруулан үр дүнг тооцно.

XVIII. Хеликобактерийн халдвар илрүүлэг үзлэгийн үр дүн

Илрүүлэг шинжилгээг 40-өөс дээш насны хүн амд хийх ба Хеликобактер Пилорийн хурдавчилсан оношлууараар удирдамж зааврын дагуу хийж үр дүнг тэмдэглэнэ. Оношлуурыг хэрэглэх зааврын дагуу хэрэглэж, үр дүнг тооцно.

Хеликобактер Пилорийн хурдавчилсан оношлуурын хариу:

1. Эерэг (+) Оношлууараар 2 тод өнгөт зурвас үүсэх. Нэг зурвас нь контрол зурвасын (С) хэсэгт нөгөө нь тест зурвасын хэсэгт үүснэ.(Т)
   (Т) хэсэгт үүсэх зурвасын өнгөний илрэл ийлдэс дэх эсрэг биеийн хэмжээнээс шалтгаалж янз бүр байх ба маш бүдэг зурвас үүссэн ч хариуг эерэг гэж үзнэ.
2. Сөрөг (-) байвал зөвхөн зурвасын (С) хэсэгт өнгөт зурвас үүснэ. .(Т) тест зурвасын хэсэгт ямар ч зурвас үүсэхгүй.
3. Эргэлзээтэй-- С) хэсэгт зурвас үүсэхгүй байвал сорьцын хэмжээ хангалтгүй байсан эсвэл ажилбарын алдаа гарсан эсэхийг тодруулж, давтан хийнэ.

Оношийн баталгаажилтийг:

1. Хеликобактер Пилорийн халдвартай /оношлууараар Эерэг (+) гарсан/
2. Хеликобактер Пилорийн халдваргүй / оношлууараар Сөрөг (-) гарсан/ гэж оншлоно

XIX. Настанд илрүүлэг хийх хураангуйлсан асуумж

Настанд эрүүл мэндийн анхан шатны байгууллага болох өрх, сумын эрүүл мэндийн төв өөрийн харьяалалд оршин суудаг 55, түүнээс дээш насны эмэгтэй, 60, түүнээс дээш насны эрэгтэйг хамруулна.

Настны өдөр тутмын бие даах чадварын болон багаж хэрэгсэлтэй ажиллах чадвар үнэлгээг Эрүүл мэндий Сайдын 2010 оны 5 дугаар сарын 31-ны 180 тоот тушаалаар батлагдсан “Настны эрүүл мэндийн үнэлгээний удирдамж”-аар батлагдсан сорилуудаар үнэлдэг.

Настны эрүүл мэндийн байдлыг хэвийн, хэвийн бус 2 хэлбэрээр ангилна.

Маягтад буй 9 асуумжаас 2 нь тийм гэсэн тохиолдолд хэвийн бус ангилалд хамаарна.

Сэтгэцийн болон зан төрхийн эмгэг: Настанд өвчний олон улсын 10-р ангиллын 5-р бүлэгт хамаарах өвчин эмгэг бүртгэгдсэн тохиолдолд бичнэ.

Насны доройтол: Настанд өвчний олон улсын 10-р ангиллын R54 кодод хамаарагдах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд бичнэ.

XX. Эмчийн ерөнхий дүгнэлт

Үзлэгийг хийж эмч ерөнхий дүгнэлт гаргана.
Үзлэгт хамрагдсан иргэнд ямар нэгэн эмгэг шинж болон өвчлөл илрээгүй тохиолдолд **Эрүүл** гэж дүгнэнэ.
Ямар нэгэн эмгэг болон өвчлөл илэрсэн тохиолдолд үндсэн өвчнийг сонгож дээрээс доош нь дараалуулах зарчмаар сонгож бичнэ. Үндсэн өвчин гэдэг нь хамгийн их оношлогоо, эмчилгээ шаардагдах өвчнийг хэлнэ.
Нэг хүнд хэдэн ч өвчлөл бүртгэгдэж болох ба авсан арга хэмжээг доорх зааврын дагуу бүртгэсэн өвчлөл тус бүрд тодорхой зааж бичнэ.

- **Амьдралын хэв маягаа өөрчлөх (зөвлөгөө)**

3. **Хооллолт** **2. Идэвхитэй хөдөлгөөн** **3. Хорт зуршил** **4.Бусад**

- Өрх, сумын ЭМТ-д хяналтанд авах **(кодоор)**

3. **3 хүртэлх сар** **2. 6 хүртэлх сар**

- Өрх, сумын ЭМТ-д эмчилгээнд хамрагдах **(кодоор)**

3. Эмийн 2. Эмийн бус

- Дээд шатлалын эмнэлэгт онош баталгаажуулах **(кодоор)**

3. Дүүргийн ЭМТ 2. АНЭ, БОЭТ3. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг 4. Хувь ЭМБ

- Дээд шатлалын эмнэлэгт эмчилгээнд хамрагдах **(кодоор)**

3. Дүүргийн ЭМТ 2. АНЭ, БОЭТ3. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг 4. Хувь ЭМБ

Үзлэгт хамрагдсан иргэний эрүүл мэндийг үзлэгийг үндэслэн эрүүл мэндийн 5 бүлэгт хамруулна.

Эрүүл мэнд, спортын сайд, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2016 оны “Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинэчлэн батлах тухай” А/252, А/74 дугаар тушаалын дагуу Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв, салбар комисс, орон нутгийн комисс, эмнэлгийн байгууллагуудын эмнэлэг, хяналтын комиссоор батлагдсан хүмүүсийг 5-р бүлэгт шууд хамруулна

Бүлэг I - Эрүүл хүмүүс

II Бүлэг – Ямар нэгэн архаг өвчингүй боловч өвчний өмнөх буюу дараах байдалд байгаа, аль нэгэн эрхтэн системын үйл ажиллагааны ба бие бялдрын зарим нэгэн хөнгөн өөрчлөлттэй, биеийн эсэргүүцэл суларсан (хурц өвчнөөр олон дахин өвчлөгсөд) хөдөлмөрийн чадвартай хүмүүс,

III Бүлэг – Архаг өвчтэй боловч тухайн эрхтэн системийн үйл ажиллагаа алдагдаагүй (компенсацийн байдал) бие махбодын зарим өөрчлөлт, эрхтэн системийн гажиг (уродство)-тай, гэмтлийн үлдэцтэй боловч ажил хөдөлмөрөө хийж байгаа хүмүүс,

IV Бүлэг – Архаг өвчнөөр удаан өвчилж, эрхтэн системд өөрчлөлт орсон (субкомпенсацийн байдал) өвчин гэмтлийн улмаас эрхтэн системийн үйл ажиллагаа буурч хөдөлмөрийн чадвар үе үе алддаг, тахир дутуугийн группд орсон хүмүүс,

V Бүлэг – Голдуу хэвтрийн дэглэм баримталдаг, декомпенсацийн байдалтай архаг хүнд өвчтэй, тахир дутуугийн 1 ба 2 группэд байдаг хүмүүс орно. Эдгээр ангиллын дагуу аль тохирох бүлгийг авч сонгож бичнэ.

Оношийн үндэслэл, хяналтын үечилсэн дүгнэлтийг эмчлэгч эмч асуултын дагуу үнэн гүйцэд маш тодорхой бичих бөгөөд хяналтын явцын байдал өөрчлөлтийг маш сайн тодорхой гаргаж бичих шаардлагатай.

Дараагийн шатлалд эмнэлэгт явуулж буй үндэслэлд онош тодруулах болон эмчилгээ хийлгэх шаардлагатай эсэхээ тэмдэглэж, анхдагч шатлалд хийгдсэн эмчилгээ, шинжилгээг амбулаторийн маягтанд дэлгэрэнгүй бичнэ.

Эмчийн үзлэгийн бүртгэл АМ-1А

Эрүүл мэндийн бүртгэл маягт АМ-1А маягтыг өрх,сумын эмч нар, АМ-1Б бүртгэлийн маягтыг амбулатори поликлиникийн үзлэгийн эмч нар өдөр бүр хөтөлж, үзлэгийг 7 хоногоор нэгтгэж статистик мэдээллийн тасаг нэгжид хүлээлгэн өгнө. Эмчийн үзлэгийн бүртгэл нь өрхийн болон сумын эмч, нарийн мэргэжлийн кабинетийн эмч нарын ажлын ачаалал болон үр дүнг үнэлэх үндсэн баримт болдог. Өрхийн эмчийн үзлэгийн бүртгэлээс ЭМТ 101.1-2 болон өвчлөлийн тайлангууд гарна.

Үзлэгийн төрөл, өвчлөлийн харгалзах нэг тоог дугуйлан тэмдэглэнэ.Өвчний улмаас амбулаторит тухайн өвчнөөр анх удаа хандвал **анх** гэснийг, 2 ба түүнээс дээш удаа үзүүлж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх шаардлага гарах тохиолдолд **давтан** гэж дугуйлна.

- Өвчний учир амбулаторийн үзлэг - ямар нэг өвчний шинж тэмдэг/ зовиур, шаналгааны улмаас эмнэлэгт хандахыг
- Урьдчилан сэргийлэх үзлэг - тодорхой зорилготой,тодорхой бүлэг хүмүүсийн дунд /албан байгууллага, сургууль,цэцэрлэг, цэрэг татлага г.м/ зориудаар хийгдсэн үзлэг
- Идэвхтэй хяналтын үзлэг –ЭМС-ын тушаалаар хяналтад авахаар заагдсан өвчний үзлэг
- Гэрийн идэвхтэй үзлэг-Өндөр настан, 0-15 насны хүүхэд, жирэмсэн эхчүүд, өртөмтгий бүлгийн хүмүүс (өрх толгойлсон эмэгтэйчүүд, ганц бие хүмүүс г.м)
- Гэрийн дуудлагын үзлэг-гэрээр нь дуудлагаар очиж үзсэн үзлэг

Үндсэн оношийг ӨОУА-10 –ын дагуу шифрлэнэ. Осол гэмтлийн өвчлөлийн тохиолдолд XIX бүлэг /S00-T99/, **Н** онош тавьсан тохиолдолд осол гэмтлийн шалтгааны V00-Y98-ын аль нь болохыг тогтоож шифрийг бичнэ.

Шинэ өвчлөл- Хүн амын дундах амбулаторит бүртгэгдсэн өвчлөлийг бүртгэх зорилгоор тухайн хүн уг өвчнөөр амьдралдаа анх удаа өвчилсөн тохиолдлыг бүртгэнэ.

Хуучин өвчлөл- Тухайн хүн урьд өвдсөн өвчин нь сэдрээд ирсэн тохиолдолд буюу архагшсан өвчлөлийг тухайн ондоо нэг удаа үзүүлэх тохиолдолд хуучин өвчлөлд тооцож авна. Хуучин өвчлөлөөр дахин давтан үзүүлсэн бол давтан үзлэгт тооцно.

Давтан үзлэг- Өвчлөл бүртгэгдсэнээс хойш эдгэрэх хүртлээ амбулатори, гэрээр эмчилгээ хийгдэж, дахин давтан ирж үзүүлсэн, шинжилгээ, боолт хийлгэсэн тохиолдолд давтан үзлэгт тооцно.

Хийгдсэн эмчилгээнээс шалтгаалан нэг буюу хоёр эмчилгээг зэрэг тэмдэглэж болно.

Эрүүл мэндийн маягт АМ-2- **Халдварт өвчлөлийг бүртгэх маягтыг** халдварт өвчин, хам шинж, сэжигтэй тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмын дагуу бүртгэнэ.

Эрүүл мэндийн маягт АМ-3- **БЗДХ-ыг мэдээлэх маягтыг бэлгийн замаар дамжих халдврын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмын дагуу бүртгэнэ.**

БЗДХ-ын шинэ тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журам, мэдээллийн урсгал

Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд

1.1 Өрх, сум (тосгон)-ын эмнэлэг, сум дундын эмнэлгийн статистикч бага эмч нь өрх, сум (тосгон)-ын үзлэгийн эмч нараас БЗДХ-ыг хам шинжээр оношлон “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас” АМ-3 маягтаар, лаборатори бүхий сум, сум дундын эмнэлэг онош батлагдсан бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ), төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас” АМ-3 маягтаар авна.

1.2 Өрх, сум (лаборатори бүхий сум, сум дундын эмнэлэг, тосгон)-ын үзлэгийн эмч нар төрөлхийн тэмбүүгийн батлагдсан тохиолдлыг “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас” АМ-3 маягтаар бүртгэж БЗДХ-ын эмчид мэдээлнэ. Цаашдын хяналт болон эмчилгээг БЗДХ-ын мэргэжлийн эмчээс зөвлөгөө авч эрүүлжүүлнэ.

1.3 Мэдээг сараар нэгтгэн нэгтгэлийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн БЗДХ-ын кабинетийн эмчид дараа сарын 3-нд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн түвшинд

2.1 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын статистик мэдээллийн алба, нэгж нь аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн статистик тасгаас онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын тоон мэдээг авч дараа сарын 4-ны дотор үндэсний түвшинд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.2 Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн статистик тасаг нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн БЗДХ-ын кабинетаас онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг бүртгэсэн “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3

маягт)-ыг ЭМЯ-наас зөвшөөрөгдсөн программд шивж цахим мэдээний санг үүсгэнэ. Цаасан (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-304 тайлан) болон цахим мэдээний санг сар, улирлаар нэгтгэн дараа сарын 10-ны дотор цахим, 20-ны дотор цаасан хэлбэрээр ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА- нд хүргүүлнэ. БЗДХ-ын шинжилгээний тайланг эрүүл мэндийн байгууллагын лабораторийн эмч, лаборант нар сар, улирлаар гарган дараа сарын 10-ны дотор цахим, 20-ны дотор цаасан хэлбэрээр ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА- нд хүргүүлнэ.

2.3 Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн төрөх, эмэгтэйчүүд, арьс өнгө, хүүхэд, нярайн тасагт төрөлхийн тэмбүүгийн сэжигтэй тохиолдлыг тухайн эмнэлэгийн БЗДХ-ын мэргэжлийн эмч, нярайн эмч хамтран оношийг баталгаажуулж, эмчлэгч эмч “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт)-ыг бичиж БЗДХ-ын кабинетийн эмчид мэдээлнэ.

2.4 Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн БЗДХ-ын кабинетийн эмч нь өрх, сумаас БЗДХ-ын хам шинжийн оношлогоо, БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг, тухайн харьяалалын БЗДХ-ын чиглэлээр ажиллаж буй ХХЭ, бусад тасаг, кабинетаас (төрөх, эмэгтэйчүүд, арьс өнгө, харшил, мэс засал…) илэрсэн БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт)-ыг хүлээн авч мэдээллийн давхардлыг шалган, оношийг баталгаажуулан эцэслэж цаасан болон цахим мэдээний санг сар, улиралаар нэгтгэн дараа сарын 5-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн статистик тасагт хүргүүлнэ.

2.5 Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн БЗДХ-ын кабинетийн эмч нь хам шинжийн оношлогооны болон онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын жилийн тайлан (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-304)-г дараа жилийн 1-р сарын 20-ны дотор ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төвүүд, БЗДХ чиглэлээр ажиллаж буй хувийн эмнэлэг

3.1 Мэдээллийн мэргэжилтэн, статистикч нь үзлэгийн кабинет, эмчилгээ, оношлогооны эмч нараас БЗДХ-ын шинэ тохиолдлыг “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас” АМ-3 маягтаар сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон авна.

3.2 ЭНЭШТ болон төрөх эмнэлгүүдэд төрөлхийн тэмбүүгийн сэжигтэй тохиолдлыг тухайн харьяалалын БЗДХ-ын мэргэжлийн эмч, нярайн эмч хамтран оношийг баталгаажуулж, эмчлэгч эмч “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт)-ыг бичиж ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нд мэдээлнэ. Эмнэлгээс гарсан тохиолдолд харьяа эмнэлгийн БЗДХ-ын мэргэжлийн эмчийн хяналтанд бүртгүүлнэ.

3.2 Сарын мэдээг өссөн дүнгээр улиралд нэгтгэн улирлын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа улирлын эхний сарын 5-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нд хүргүүлнэ.

Үндэсний түвшинд

4.1 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА нь мэдээний эх сурвалж байгууллагуудаас БЗДХ-ын хам шинжийн оношлогоо, онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг бүртгэсэн “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт)-ын цахим баазыг дараа сарын 10-ны дотор, цаасан хэлбэрээр 20 ны дотор хүлээн авна.

4.2 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-ны статистикч бага эмч нь өөрийн байгууллагын үзлэгийн кабинет, эмчилгээ, оношлогооны эмч нараас онош батлагдсан БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг бүртгэсэн “Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт) маягтаар 7 хоног бүр хүлээн авч сар, улирлаар нэгтгэн гаргаж ЭМЯ-наас зөвшөөрөгдсөн программд шивж цахим мэдээний санг үүсгэн улсын хэмжээний тайлангийн нэгтгэлд оруулна.

4.3 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нь БЗДХ-ын хам шинжийн оношлогоо, онош батлагдсан ДОХ/БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлын мэдээний санг үндэсний түвшинд нэгтгэн, боловсруулалт, дүн шинжилгээ хийн ЗГХА-ЭМГ-ЭМСМХ-т дараа сарын 20-ны дотор цахим хэлбэрээр мэдээлнэ.

4.4 ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХТСА-нь БЗДХ-ын хам шинжийн оношлогоо, онош батлагдсан ДОХ/БЗДХ, төрөлхийн тэмбүүгийн тохиолдлыг ДОХ/БЗДХ-ын шалтгаант нас баралтын жилийн тайланг (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-304) нэгтгэн үндэсний түвшинд цахим болон цаасан хэлбэрээр дараа оны 2-р сарын 15-ны дотор хүргүүлнэ.

“Бэлгийн замаар дамжих халдварыг мэдээлэх хуудас”(АМ-3 маягт)
<u>хөтлөх</u> заавар

Асуумж	*Аргачлал-Тодорхойлолт-Жишээ*
Эмнэлгийн нэр	2 0 0 2 1 2 УБ хот/аймаг/ Дүүрэг /сум/ Эмнэлгийн нэр
Хувь хүний тухай мэдээлэл	
Дугаар 1.2 эцэг эхийн нэр, нэр	Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн тод гаргацтай, татлахгүйгээр үнэн зөв бичнэ
Дугаар 3: Өвчтний регистрийн дугаар	Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Анхаарах зүйл: РД гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр дармалаар, сүүлийн 8 нүдэнд цифрийг нүд тус бүрт гаргацтай тод бичнэ. Жишээ нь: А Ю 7 8 1 2 2 9 1 3
Дугаар 4.5: Өвчтөний нас, хүйс	На сыг асууж гараар бичиж оруулна. Эрэгтэй- 1, Эмэгтэй бол 2-ийг зурна.
Дугаар 6: Жирэмсэн	Тийм- 1, үгүй- 2 дугуйлна.
Дугаар 7: Тогтмол хаяг: Утас: Ажлын газар, албан тушаал	Өвчтөний иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг, хот, сум, дүүрэг, хороо, хаалганы дугаар зэргийг гаргацтай тод гараар бичиж оруулна. Ажиллаж байгаа албан тушаал болон ажлын газрыг бичнэ

Дугаар 8: Боловсрол	Боловсрол бага -1 /дунд сургуулийн 1- 4-р ангийг төгссөн / Боловсрол дунд-2 /дунд сургуулийн 5-11-р ангийг төгссөн/ Боловсрол мэргэжил-техникийн-3 /Мэргэжлийн болон техникийн коллеж төгссөн/ Боловсрол дээд-4 /Их дээд сургууль төгссөн/ Боловсролгүй -5 /ямар нэгэн сургууль төгсөөгүй буюу сургуульд ороогүйг хамааруулна/
Дугаар 9: Гэр бүлийн байдал	Гэрлээгүй-1, Гэрлэсэн -2, Салсан-3, Бэлэвсэн-4, Хамтран амьдрагчтай-5 аль тохирохыг дугуйлна.
Дугаар 10: Нийгмийн байдал	Ажил эрхэлдэг -1 Ажил эрхэлдэггүй-2 Оюутан-3 0-15 насны хүүхэд-4 Цэргийн албан хаагч, цэрэг-5 Тэтгэвэрт-6 Бусад-7
Дугаар 10: Илрүүлэлт	Урьдчилан сэргийлэлт -1 Өвчний учир амбулаторт-2 Амбулаторийн хяналт -3 Хавьтлаас -4 Сайн дурааараа-5 Эмнэлгээс бусад /нэрийг тодорхой бичнэ үү/ -6 ……
II. БЗДХ-ын мэдээлэл	
Дугаар 12. Онош, оношийн үе шат	**2 дах шатлалаас онош батлагдсан шинэ БЗДХ Тэмбүү: 1-р үе шат/A51.1/** 2-р үе шат /A51.2/ 3-р үе шат /A51.3/ Далд /A51.4/ Төрөлхийн тэмбүү /A50.0/ Заг хүйтэн: Хүндэрсэн /A54.1/ Хүндрээгүй /A54.2/ Трихомониаз /A59.0/ Шээс бэлгийн замын хламид /A56.0/ Шээс бэлгийн замын мөөгөнцөр /B37.3 эм, B37.4 эр/ Нянгийн гаралтай үтрээний үрэвсэл /N76/ Бэлгийн герпес /A60.0/ Микоплазм Уреаплазм Бэлгийн үү /A63.0/
Дугаар 12. Хам шинжийн оношлогоо	Бэлгийн шархлаа Шээсний сувгийн ялгадас Үтрээний ялгадас Хэвлийн доод хэсгийн өвдөлт Төмсөг хавдах Цавины булчирхай томрох Нярайн нүдний салстын үрэвсэл

Дугаар 13. Халдварын эх уурхай	Бэлгийн хавьтлаар: Биеэ үнэлэгч-1А Байнгын бэлгийн хавьтал-1Б Тохиолдлын бэлгийн хавьтал-1В Цус, цусан бүтээгдэхүүн сэлбүүлсэн-2 Эхээс хүүхдэд халдварласан-3 Тодорхой бус-4
Дугаар 14.Онош баталгаажилт	Энгийн хурдавчилсан сорил-1 PRP-2 TPHA-3 ФХЭБУ/ELIZA/-4 Полимеразын гинжин урвал-5 Өсгөвөр-6 наац-7 Нойтон түрхэц-8
Дугаар 15. Мэдээлсэн эмчийн нэр	Тухайн БЗДХ-ын шинэ тохиолдлыг мэдээлсэн их эмч

Эрүүл мэндийн маягт АМ-4- Шинээр илэрсэн сүрьеэ өвчнийг **мэдээлэх маягтыг сүрьеэ өвчнийг бүртгэх мэдээлэх журмын дагуу бүртгэнэ.**

Эрүүл мэндийн маягт АМ-5-Хорт хавдрыг **мэдээлэх маягт**
Хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг мэдээлэх хугацаа, урсгал

Өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвийн түвшинд

1. Өрх, сум (тосгон)-ын эмнэлэг, сум дундын эмнэлгийн статистикч бага эмч нь өрх, сум (тосгон)-ын үзлэгийн эмч нараас хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5", хорт хавдрын шалтгаант нас баралтыг "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7" мэдээг өдөр бүр авна.

2. Мэдээг долоо хоног, сараар нэгтгэн нэгтгэлийг сар бүрийн сүүлийн өдрөөр тасалбар болгон аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасаг, нэгжийн хавдар бүртгэгчид дараа сарын 1-нд цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн түвшинд

1. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын статистик мэдээллийн алба, нэгж нь хавдар бүртгэгчээс хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын тохиолдлын тоон мэдээг авч дараа сарын 4-ны дотор ЗГХА-ЭМГазрын СМХэлтэст цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч нь аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, хувийн эмнэлэг, лабораториос улирал бүрийн сүүлийн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа улирлын эхний сарын 2-ны дотор "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5" "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7" -г цаасан болон цахим хэлбэрээр мэдээллийг хүлээж авна.

3. "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5", "Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7" маягтын өгөгдлийг ЭМЯ-наас зөвшөөрөгдсөн программд хавдар бүртгэгч шивж мэдээний санд мэдээллийн давхардлыг шалган, мэдээний санг үүсгэнэ.

4. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын цаасан болон цахим мэдээний санг улирлаар нэгтгэн дараа улирлын эхний сарын 10-ны дотор цахим хэлбэрээр, 20-ны дотор цаасан хэлбэрээр ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд хүргүүлнэ.

5. Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн хавдрын тасгийн хавдар бүртгэгч хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын жилийн тайлан (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-303)-г дараа жилийн 1-р сарын 15-ны дотор ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

Төв эмнэлэг, Тусгай мэргэжлийн төвүүд, хувийн эмнэлэг болон бусад эмнэлэг

1. Мэдээллийн мэргэжилтэн, статистикч нь үзлэгийн кабинет, эмчилгээ, оношлогооны эмч нараас хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг "Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5",

хорт хавдрын шалтгаант нас баралтыг “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7” маягтаар өдөр бүр хүлээн авна.

2. Сарын мэдээг өссөн дүнгээр улиралд нэгтгэн улирлын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа улирлын эхний сарын 5-ны дотор цахим болон цаасан хэлбэрээр ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд хүргүүлнэ.

Үндэсний түвшинд

1. ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэл нь мэдээний эх сурвалж байгууллагуудаас “Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5 ” хорт хавдрын шалтгаант нас баралтыг “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7” маягтын цахим баазыг дараа улирлын эхний сарын 10-ны дотор, цаасан хэлбэрээр 20 ны дотор хүлээн авна.

2. ХСҮТ-ийн амбулатори, стационари хариуцсан статистикч их эмч нь үзлэгийн кабинет, эмчилгээ, оношлогооны эмч нараас хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг “Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5” хорт хавдрын шалтгаант нас баралтыг “Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-7” маягтаар өдөр бүр хүлээн авч сар, улирлаар нэгтгэн улирлын сүүлийн сарын 30-д ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэлд цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3. ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэл нь хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын мэдээний санг үндэсний түвшинд нэгтгэн, боловсруулалт, дүн шинжилгээ хийн ЗГХА-ЭМГазрын ЭМСХэлтэст улирал тутмын дараа сарын 20-ны дотор цахим хэлбэрээр мэдээлнэ.

4. ХСҮТ-Хавдрын үндэсний бүртгэл нь хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдол, хорт хавдрын шалтгаант нас баралтын жилийн тайланг (Захиргааны статистикийн мэдээлэл ЭМТ-303) нэгтгэн жил бүрийн 2-р сарын 15-ны дотор ЗГХА-ЭМГазрын ЭМСХэлтэст цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

<u>Хорт хавдрыг мэдээлэх хуудас АМ-5 хөтлөх зааварчилгаа</u>

Асуумж	Аргачлал-Тодорхойлолт - Жишээ
I. Хувь хүний тухай мэдээлэл	
Дугаар 1-3: Өвчтний ургийн овог, эцэг эхийн нэр, нэр	Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн тод гаргацтай, татлахгүйгээр үнэн зөв бичнэ
Дугаар 4: Өвчтний регистрийн дугаар	Иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Анхаарах зүйл: РД гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр дармалаар, сүүлийн 8 нүдэнд цифрийг нүд тус бүрт гаргацтай тод бичнэ. Жишээ нь:

	А Ю 7 8 1 2 2 9 1 3
Дугаар 5: Өвчтөний нас	Нас гэсэн 3 нүд бүхийн хүснэгтэд насыг бичихдээ төрсөн он сарыг үндэслэн насыг тооцоолж эхний нүдэнд зуутын орон, дунд нүдэнд аравтын орон, сүүлийн нүдэнд нэгжийн орон байхаар тохируулж бичнэ. Жишээ нь: насыг тооцоход 3 настай гэж гарсан бол 0 0 3 гэж бичнэ. Хэрэв сар болон хоногтой бол нэгжийн оронг 0 болгож хүснэгтийн гадна тоог тавиад сар, хоног аль нь болохыг бичнэ. Анхаарах зүйл: Өвчтөний насыг мэдэх боломжгүй, нотлох бичиг баримт огт байхгүй бол - хорт хавдрын онош тавигдсан он сар өдрөөр тооцоолно.
Дугаар 6: Хүйс	Эрэгтэй- 1, Эмэгтэй бол 2-ийг дугуйлна
Дугаар 7: Боловсрол	Боловсрол бага -1 /дунд сургуулийн 1- 4-р ангийг төгссөн / Боловсрол дунд-2 /дунд сургуулийн 5-11-р ангийг төгссөн/ Боловсрол мэрэгжлийн-3 /Мэргэжлийн болон техникийн коллеж төгссөн/ Боловсрол дээд-4 /Их дээд сургууль төгссөн/ Боловсролгүй -5 /ямар нэгэн сургууль төгсөөгүй буюу сургуульд ороогүйг хамааруулна/
Дугаар 8: Төрсөн он, сар, өдөр	Асуултанд харгалзах 8 нүд бүхий хүснэгтэнд эхний 2 нүдэнд өдөр, дараагийн 2 нүдэнд сар, сүүлийн 4 нүдэнд оныг бүтнээр бичнэ. Төрсөн он сар өдрийг бичихдээ өвчтөний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн бичнэ. Жишээ: 1961 он 09 сар 17 1 7 0 9 1 9 6 1 Анхаарах зүйл: Төрсний гэрчилгээ аваагүй бол төрөлтийн түүхэн дэхь төрсөн он сар өдрийг бичнэ. Төрсөн он сарыг мэдэх боломжгүй тохиолдолд оныг мэдэж

	байвал сар өдрийг 01 сарын 01-ээр авна.
Дугаар 9: Ажлын газар	Өвчтөний хорт хавдрын онош батлагдах үед хийж гүйцэтгэж байгаа ажлын газрыг бичнэ. Харгалзах 2 нүдэнд ажлын газрын кодыг ЭМСайдын 34-р тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхтгэл номын Хүснэгт №3-ийг ашиглана. Жишээ: Боловсролын салбарт ажилладаг бол [1][6] гэж бичнэ. Анхааруулга: Ажлын газаргүй буюу аль нэг кодод ороогүй ажлын газар бол 22-ыг сонгоно.
Дугаар 10: Албан тушаал	Хорт хавдрын онош тавигдах үеийн албан тушаалыг бичнэ. Харгалзах 2 нүдэнд албан тушаалын кодыг доорхи жагсаалтыг ашиглан бичнэ. Ажилчин-1 Албан хаагч-2 Малчин-3 Тэтгэвэрт-4 Оюутан-5 0-15 насны хүүхэд-6 Групп болон бусад-7 Ажилгүй-8 Жишээ: Их эмч бол албан тушаалыг албан хаагчаар авна. [0][2] гэж кодлон бичнэ
Дугаар 11: Мэргэжил	Өвчний амьдралынхаа ихэнх хугацаанд ажиллаж өнгөрүүлсэн болон тухайн мэргэжилээр нарийвчлан сурч ажилласан мэргэжлийг бичнэ. Харгалзах 2 нүдэнд доорхи кодуудаас сонгон бичнэ. ЭМСайдын 34-р тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхтгэл номын Хүснэгт №4-ийг ашиглана.

	Жишээ: мэргэжил багш бол 0 4 гэж бичнэ.
Дугаар 12: Гэрлэлтийн байдал	Гэрлэсэн бол-1, Гэрлээгүй бол -2, тодорхойгүй бол – 3-ийн аль тохирохыг сонгон дугуйлна.
Дугаар 13: Одоогийн оршин суугаа хаяг Холбогдох утас:	Өвчтөний иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг, хот, сум, дүүрэг, хороо, хаалганы дугаар зэргийг гаргацтай тод бичнэ. Харгалзах 6 нүд бүхий хүснэгтэнд ЭМСайдын 34-р тушаалаар батлагдсан маягт бүртгэлийн эмхэтгэл номын Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн ангилал Хүснэгт №1-ийг ашиглан кодыг сонгон эхний 2 нүдэнд аймаг, хотын, дунд 2 нүдэнд сум, дүүргийн, сүүлийн 2 нүдэнд баг, хорооны кодыг бичнэ. Жишээ: Хөвсгөл аймгийн рашаант сум 1-р хороо гэсэн бол 1 7 1 1 0 1 гэж бичнэ. Холбогдох утас: өвчтөнтэй холбоо барих ар гэрийнхэний, өвчтөний өөрийн утасны дугаарыг нэг бүрчлэн бичнэ.
Дугаар 14: Хорт хавдар оношилсон Эрүүл Мэндийн Байгууллага	Хорт хавдрыг оношилсон Эрүүл Мэндийн Байгууллагыг сонгон дугуйлна.
II. Хорт хавдрын мэдээлэл	
Дугаар 15: Хавдрыг оношилсон огноо	Хавдрыг оношлосон шинжилгээ ба бусад үндэслэлийн дагуу хавдрын онош батлагдсан хамгийн эхний он, сар, өдрийг тооцон тавина.
Дугаар 16 : Өвчтөний одоогийн байдал	Хорт хавдар оношлогдох үед тухайн хүний байдал Амьд-1, Нас барсан-2, Тодорхойгүй-3 –ийн аль тохирохыг сонгон дугуйлна. Нас барсан огноог нас баралтын гэрчилгээг үндэслэн бичнэ.
Дугаар 17 : Анхдагч хавдрын	Хүний биеийн эрхтэн системийн аль хэсэгт хавдар байрлаж байгааг тодорхой заасан

байрлалын онош	оношыг дэлгэрэнгүй бичнэ. Өөрөөр хэлбэл Өвчний олон улсын ангилал - Хавдар судлалыг ашиглан анхдагч хавдрын байрлалын оношийг бичмэлээр тавина.
Дугаар 18: Олон улсын өвчний ангилал-хавдар судлал-3	Олон улсын өвчиний ангилал-хавдар судлал-3 тавина. Жишээ: Ходоодны их биеийн хэсгийг хамарсан хорт хавдар С16.3 гэж кодлоно. Өвчний олон улсын ангилал - Хавдар судлал цусны хорт хавдрын / лейкеми/ С42 С 1 6 . 3
Дугаар 19: Морфологийн онош	Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн төрөл, төлөв байдлыг дэлгэрэнгүй бичнэ
Дугаар 19.1: Хавдрын төлөв	Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн төлөв байдлыг үндэслэн аль тохирохыг дугуйлна.
Дугаар 19.2: Эсийн ялгарал	Эд, эсийн шинжилгээний дүгнэлтээс хавдрын эсийн ялгаралыг сонгон тохирохыг дугуйлна.
Дугаар 19.3: Лимфома, лейкемийн эсийн ялгарал	Цусны хавдруудын үед эсийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн аль тохирохыг дугуйлна.
Дугаар 20. Хавдрын бүтэц зүйн оношийн код	**М** үсгээр эхэлсэн 8 нүд бүхий хүснэгтэнд Олон улсын өвчний ангилал-хавдар судлал-3 номыг ашиглан хавдрын бүтэц зүйн оношыг кодоор бичнэ. Эхний нүдэнд **М** үсэг, дараагийн 4 нүдэнд хавдрын эсийн төрөл, 6 дах нүдэнд ташуу зураас, 7 дахь нүдэнд хавдрын эсийн төлөв, 8 дах нүдэнд хавдрын эсийн ялгаралын кодуудыг бичнэ. Жишээ нь: Аденокарцинома- хортой, бага ялгаралтай бол **М** 8 1 4 0 / 3 3
Дугаар 21. Анхдагч олон байрлалын хавдар мөн эсэх	Анхдагч ганц байрлалын хавдар -1 Анхдагч олон байрлалын хавдрын нэг тохиолдол-2 Тодорхойгүй -3

Дугаар 21.1 Хос эрхтний хавдар мөн эсэх:	Баруун -1 Зүүн -2 Нэг талыг хамарсан боловч ялгаж тусгаагүй -3 Хоёр талыг хамарсан - 4 Хос эрхтэн бус -5
Дугаар 22. Хавдрыг оношлосон шинжилгээ ба үндэслэл	Бичил харуурын болон бичил харуурын бус хүснэгтээс аль тохирохыг дугуйлна
Дугаар 23. Оношлогдох үеийн хавдрын үе шат /Олон улсын TNM ангилалыг баримтлан тавина/	**Т- нь анхдагч хавдрын хэмжээ /тархалт/** Т-is Байран өмөн То- Анхдагч хавдар тодорхойлогдохгүй Т1,Т2,Т3,Т4-Анхдагч хавдрын тархалтыг тодорхойлно **N- Хавдар орчмын тунгалгийн булчирхай** No- Тунгалагийн булчирхайг гэмтээсэн шинж тэмдэггүй. N1,N2, N3- Тунгалагийн булчирхайг хир зэрэг гэмтээснийг илэрхийлнэ. Nx- Тунгалагийн булчирхай гэмтсэнийг тогтоох боломжгүй. **М- Эрхтэнд үсэрхийлэлтэй эсэхийг харуулна** Мо- Алсын эрхтэнд үсэрхийлэлийн шинж тэмдэггүй. М1- Алсын эрхтэнд үсэрхийлэлтэй. Мх- Алсын эрхтэнд үсэрхийлэл байгаа эсэхийг тогтоох боломжгүй
Дугаар 24. Хавдрын эмнэл зүйн үе шат	I, II, III, IV Ромбо тоог ашиглан хавдрыг эмнэл зүйгээр нь үе шатаар ангилна.
Дугаар 25. Хийгдсэн эмчилгээ	Хавдрын онош батлагдсан үеэс эхлэн эхний курс эмчилгээний төлөвлөгөө болон хийсэн эмчилгээг эмчилгээний хүснэгтээс аль тохирохыг сонгон харгалзах тоог дугуйлна.

Дугаар 26-26.1. Хийгдсэн мэс заслын нэр, мэс засал хийсэн эмнэлэг, эмч	Мэс заслын нэрийг дэлгэрэнгүй гаргацтай тод бичнэ. Мэс заслын үйлдлийн кодыг ICD-9-CM- Үйлдлийн Олон Улсын ангилал 9 - III ботийг ашиглана.
III. Мэдээний эх сурвалж: /Хорт хавдрын шинэ тохиолдол нь шүүх эмнэлэг, эмгэг судлалын шинжилгээгээр батлагдсан тохиолдолд мөн бөглөнө/	
Дугаар 27-27.1-4.Мэдээлсэн байгууллагын нэр, мэдээлэгдсэн баримтын дугаар, шинжилгээний дүгнэлт	Хорт хавдрыг оношилсон лаборатори, эмгэг судлалын төв, шүүх эмнэлгээс мэдээлэгдэж байгаа тохиолдол байгууллагын нэр, баримтын дугаар, шинжилгээний дүгнэлтийг дэлгэрэнгүй бичиж АМ-5 маягтын <u>I. Хувь хүний мэдээллийн</u> хэсгийг заавал бөглөнө. Хорт хавдрыг мэдээлж байгаа бусад эрүүл мэндийн байгууллагууд байгууллагынхаа нэрийг бичмэлээр бичин эрүүл мэндийн сайдын 34 тоот тушаалд заагдсан кодыг нүдэнд бичнэ. Жишээ нь: ХСҮТ мэдээлэгдсэн бол: 20- Улаанбаатар хот (2 0 0 2 1 1) 02- Баянзүрх дүүрэг 11- ХСҮТ
Дугаар 28. Бусад эх сурвалж	Эмнэлгийн бус мэдээний эх сурвалж байгууллагуудаас мэдээлэгдэх тохиолдолд тухай оныг тавин 99 тоогоор кодлоно
Дугаар 29. Мэдээлсэн эмчийн нэр	Тухайн хорт хавдрын өвчлөлийн шинэ тохиолдлыг мэдээлсэн их эмч
Дугаар 30. Хүлээн авсан бүртгэлийн ажилтан	Аймаг, дүүргийн хавдрын бүртгэлийн ажилтан уг маягтыг хүлээн аваад бүрэн хөтлөгдсөн эсэхийг шалгаж мэдээлэл бүрэн болсон тохиолдолд мэдээлнэ

***Эрүүл мэндийн маягт АМ-6-* Халдварт бус өвчлөлийг бүртгэх хуудас /зөвхөн цахимаар бүртгэнэ./**

Халдварт бус өвчлөлийг бүртгэх хуудас бичих үндсэн материал нь “Эмчийн үзлэгийн бүртгэлийн маягт АМ-1 А, Б болно. Энэхүү бүртгэлийн маягтаас хүн амын халдварт бус

өвчлөлийн тайлан гарна. Үзлэгийн эмч өвчлөл бүртгэсэн тохиолдол бүрт уг хуудсыг бичиж хөтлөх ба бичихгүй тохиолдол нь:

1. Онош бүрэн тогтоогдоогүй
2. Халдварт өвчин (Халдварт өвчнийг мэдээлэх хуудас-АМ-2)
3. Хуучин өвчлөлийг тухайн онд анх эмнэлэгт хандсан тохиолдолд бүртгээд тухайн өвчнөөр давтан ирсэн тохиолдолд

Тухайн маягтыг үнэн зөв хөтөлсөн эсэхэд статистикч их, бага эмч нар хяналт тавьж программд шивж оруулна. /Health-info 3.0/

Осол гэмтлийн өвчлөл бүртгэгдсэн тохиолдолд шалтгааныг заавал тодорхойлж V01-Y98 аль нь болохыг тогтоож шифрлэнэ.

Эрүүл мэндийн маягт АМ-7- Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ хөтлөх заавар

Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээг нас барсан хэлбэр, хаана нас барсныг харгалзахгүйгээр үйлчлэх нутаг дэвсгэрт нас барсан бүх тохиолдолд бичнэ. Гэрчилгээг иргэний бүртгэл мэдээллийн төвд бүртгүүлэхээр 2 хувь бичиж 1 хувийг нас барагчийн ар гэр, төрөл төрөгсдөд олгож, нөгөө хувийг нь эмнэлгийн статистик мэдээллийн тасагт хүлээлгэн өгнө. Статистик мэдээллийн тасагт статистикч их эмч бичлэг, кодлолтын үнэн зөвийг шалгаж, комьпютерт шивнэ. Комьпютерт шивсэн энэхүү анхан шатны бүртгэлийн маягтаас хүн амын нас баралтын тайлан насны ангилал, нас баралтын хэлбэрээр, нас барсан газраар гаргана. Гэрчилгээг заавал их эмч хөтөлнө. Багийн бага эмчийн салбарт гэрчилгээг бага эмч бичиж нас баралтын шалтгааныг заавал сумын эрүүл мэндийн төвийн их эмчээр хянуулна. Нас баралтын үндсэн шалтгааныг тогтоохдоо нас барагчийг урьд нь эмчилж байсан эмнэлэг, өрхийн эмчийн хяналтыг үндэслэж эсвэл задлан шинжилгээ хийсний үндсэн дээр бичнэ. Аймаг хотын болон сумын эрүүл мэндийн төвд хэвтэж эмчлэгдэж байгаад нас барагсад гадны шалтгаанаар нас барсан байж болох сэжигтэй бүх тохиолдолд заавал задлан шинжилгээ хийсний үндсэн дээр уг гэрчилгээг бичнэ. Гадны шалтгаант нас баралтын үндсэн оношийг ӨОУА 10-ын XX бүлгээр кодлоно. Гэрчилгээг бөглөхдөө асуултын дагуух харалдаа хэсэгт байгаа шифрийг чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ. Эмчийн зурж тэмдэглэсэн шифрийг шууд комьпютерт оруулж шивнэ.

Хорт хавдар болон ХДХВ/ДОХ-ын шалтгаанаар нас барсан тохиолдолд оношилогдсноос хойш амьдарсан хугацааг жил, сар, хоногоор тооцож бичнэ.

Нас баралтын шалтгаан

Дэлхийн эрүүл мэндийн байгууллаас нас баралтын гэрчилгээнд бичигдэх нас баралтын шалтгааныг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

“үхэлд хүргэсэн эсвэл үхэлд хүрэхэд нь дэмжлэг үзүүлсэн бүх л өвчин, эмгэг, гэмтэл ба энэ гэмтлийг бий болгосон ослын нөхцөл байдал, хүчирхийллийг бүгдийг оруулна” гэж заасан. Энэ тодорхойлолтын зорилго нь холбогдох бүх мэдээллийг нь тайланд оруулах явдал бөгөөд гэрчилгээ олгож байгаа эмч зарим шалтгааныг нь хасах эсвэл сонголт хийх ёсгүй. Зүрхний эсвэл амьсгалын дутагдал гэх мэтээр нас баралтын шалтгааныг тодорхойлохгүй.

Нас баралтын үндсэн шалтгааныг тэмдэглэх

Нас баралтын гол шалтгааныг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

“а) нас баралтад хүргэсэн эмгэг нөхцөл байдлыг үүсгэсэн өвчин эсвэл гэмтэл, эсвэл б) маш хүнд үхлийн гэмтэл үүсгэсэн осол эсвэл хүчирхийллийн нөхцөл байдал” гэж тодорхойлсон.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын чуулганаас дээрх зарчмуудыг улс орнуудад хэрэглэхийг зөвлөсөн. Эмч, эмнэлгийн ажилтны үүрэг бол нас барсан тухай гэрчилгээ бичихдээ үхэлд шууд хүргэсэн эмгэг нөхцөл байдал ба энэ шалтгааныг үүсэхэд нь нөлөөлсөн өмнөх нөхцөл байдлуудыг нь оруулах явдал юм.

Нас барсан тухай гэрчилгээ нь 2 ба түүнээс олон шалтгаан бичигдсэн тохиолдолд гол шалтгааныг нь сонгох үйл явцад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор загварчлагдсан. Энэ гэрчилгээний 1-р хэсэг нь үхэлд шууд хүргэсэн эмгэг нөхцөл байдлуудыг, 2-р хэсэг нь шууд холбоогүй боловч дэмжлэг үзүүлсэн нөхцлүүдийг харуулна.

Зарим тохиолдолд ӨОУА нь хүснэгтэн мэдээлэлд бичигдэх гол шалтгааныг илэрхийлэхдээ урьдал шалтгааныг хавсруулах боломжийг олгодог. Жишээ нь нийлмэл тохиолдлыг илэрхийлэх эсвэл гэрчилгээнд бичигдсэнээс өөр илүү чухал ач холбогдолтой тархвар зүйн шалтгаан байж болно.

Тийм учраас дараагийн алхам бол дээрх тохиолдолд дараах дүрмүүдийг баримтлана.

Урьдал шалтгаан нь осол гэмтэл эсвэл 19-р бүлэгт ангилагдсан гадаад шалтгаан байвал тухайн байдлыг үүсгэсэн нөхцлийг хүснэгтэн мэдээлэлд бичиж оруулах нас баралтын гол шалтгаан гэж үзэн V01-Y89 хүртэлх кодоос сонгон кодлоно. Тухайн гэмтэл эсвэл гадаад шалтгааны кодыг нэмэлтээр авч болно.

Дүрэм А
Зөнөгрөл ба бусад тодорхойгүй нөхцөл байдал

Сонгосон шалтгаан нь тодорхойгүй нөхцөл байдал байх ба гэрчилгээнд өөр төрлийн ангилагдсан шалтгаан бүртгэгдсэн байвал нас баралтын шалтгааныг дахин сонгоно. Дахин сонголт хийхдээ тодорхойгүй нөхцөл байдал нь кодлоход нөлөө үзүүлэхгүй л бол түүнийг гэрчилгээнд бичигдээгүй байсан мэтээр үзнэ.

Дараах нөхцөл байдлуудыг тодорхойгүй гэж үзнэ. Үүнд: I46.9 буюу тодорхойгүй шалтгаанаар зүрх зогсох, I95.9 буюу шалтгаан нь тодорхойгүй даралт багасах, I99 буюу цусны эргэлтийн тогтолцооны бусад ба тодорхойгүй эмгэг, J96.0 буюу амьсгалын цочмог дутмагшил, J96.9 буюу шалтгаан нь тодорхойгүй амьсгалын дутмагшил, P28.5 буюу нярайн амьсгалын дутмагшил, R00-R94 ба R96-R99 буюу өөр бүлэгт ангилаагүй шинж тэмдэг, зовиур, эмнэлзүйн ба лабораторийн хэвийн бус үзүүлэлтүүд орно. R95 буюу нярай гэнэт эндэх хамшинжийг эмгэг гэж тодорхойлсон нөхцөл байдалд хамааруулж үзэхгүй.

Дүрэм В
Ач холбогдол багатай нөхцөл байдал

Нас баралтын шалтгаан гэж сонгосон нөхцөл байдал нь тиймч ач холбогдолтой бус харин түүнээс илүү хэмжээгээр үхэлд нөлөөлсөн нөхцөл байдал гэрчилгээнд бичигдсэн бол сонголтыг дахин хийнэ. Дахин сонголт хийхдээ ач холбогдол багатай нөхцөл байдал нь гэрчилгээнд тэмдэглэгдээгүй байсан мэтээр үзнэ. Хэрэв үхэл нь ач холбогдол багатай нөхцөл

байдлыг эмчлэх эмчилгээний сөрөг үр дагавраас шалтгаалсан байвал үр дагаврыг нь шалтгаан гэж үзнэ

Дүрэм С
Холбоос

Нас баралтын сонгосон шалтгаан нь гэрчилгээнд бичигдсэн нэг ба олон нөхцөл байдалтай холбогдож байвал хооронд нь холбож кодлоно. Холбож кодлохдоо өөр нөхцөл байдлаас шалтгаалан үүссэн нэг л нөхцөл байдлыг авч үзэх бөгөөд учир шалтгааны холбоосыг зөв олсон байх хэрэгтэй. Холбоос хийхэд зөрчилтэй асуудал гарч ирвэл анхны сонгосон шалтгааныг гэрчилгээнд бичигдээгүй байсан мэтээр үзэж, сонголтыг хийнэ. Боломжтой бол нэгээс олон холбоос хийж болно.

Дүрэм D
Өвөрмөц байдал

Нас баралтын шалтгаан гэж сонгосон нөхцөл нь ерөнхий нэр томъёогоор илэрхийлэгдсэн бөгөөд гэрчилгээнд энэ нөхцөл байдлыг илүү нарийн тодорхойлсон нэр томъёо бичигдсэн байвал илүү мэдээлэл өгөх нэр томъёог нь сонгож авна. Ерөнхий нэр томъёо нь тэмдэг нэр байх тохиолдолд энэ дүрмийг ихэвчлэн хэрэглэдэг.
Дүрэм Е
Өвчний эрт ба төгсгөлийн шат

Нас баралтын сонгосон шалтгаан нь өвчний эрт үеийг илэрхийлж байгаад гэрчилгээнд түүнээс дараа үе шатны тухай нэр томъёо бичигдсэн байвал хамгийн сүүлийн үе шатаар нь шалтгааныг сонгож авна. Ямар нэгэн өвөрмөц заавар өгөөгүй тохиолдолд “цочмог” хэлбэрээс болсон “архаг” нөхцөл байдлыг шалтгаан гэж сонгож авахгүй.

Дүрэм F
Үр дагаврын категорууд

Нас баралтын шалтгаан гэж сонгосон шалтгаан нь ямар нэгэн өвчний үр дагаврын категорийн эхний нөхцөл байдал байгаад үхэл нь энэ үр дагаврын категоруудад байгаа бусад нөхцөл байдлаас улбаалсан бол үр дагаврын категорийн дугаараар кодлоно.

Дараах категорууд нь үр дагаврын категорууд юм: B90-B94, E64.-, E68, G09, I69.-, O97, T90-T98, Y85-Y89

Эрүүл мэндийн маягт АМ-8- Эмнэлгийн магадлагаа бүртгэлийн маягтыг хөтлөх заавар

Эмнэлгийн магадлагаа маягтыг амбулаторийн эмчлэгч эмч олгоно. Тогтмол хаяг, ажлын газар, албан тушаал, мэргэжлийг загвар маягтын дагуу бичиж тэмдэглэнэ. Эмчлэгч эмч магадлагаа олгох болсон шалтгааныг тодруулж /өвчтэй байсан, өвчтөн асрамжилсан, хөл хоригдсон, хичээлээс биеийн эрүүл мэндийн байдлаас чөлөөлөгдөх/ магадлагааг ерөнхий эмчээр баталгаажуулж олгоно. Сунгалтыг 3 өдрөөр 3 удаа олгох ба энэ тохиолдолд эмчлэгч эмч тэмдэг, гарын үсгээр баталгаажуулна.

Эрүүл мэндийн маягт АМ-9А, 9Б- Эмийн жорын бүртгэлийн маягтыг хөтлөх заавар

Эмийн жорыг Монгол улсын Стандартчилал, Хэмжил зүйн үндсэний төвөөс баталсан “Эмийн жорын маягт, жор бичилт” MNS 5376;2004 стандартанд заасны дагуу бичнэ.
Үүнд:

1. Энгийн эмийн жор 100*160мм хэмжээтэй хэвлэмэл маягт дээр бичнэ.
2. Мансууруулах эмийн жорын хэвлэмэл маягтыг нэгдсэн дугаартайгаар хэвлэж, төрийн захиргааны холбогдох төв байгууллага тэмдэг дарж баталгаажуулсан байна.
3. Мансууруулах эмийн жорын маягтыг жор бичих дүрмийг баримтална.

Өвчтөн илгээх хуудас эрүүл мэндийн маягт АМ-13 А

13А- маягтыг өрх, сумын эрүүл мэндийн төвийн их эмч дараагийн шатлалд шилжүүлэх шаардлагатай хүмүүст олгоно.
Ажлын газар, албан тушаал, мэргэжлийг шифрлэхдээ салбарын үндсэн ангилалын дагуу шифрлэнэ.
Дараагийн шатлалд эмнэлэгт явуулж буй үндэслэлд онош тодруулах болон эмчилгээ хийлгэх шаардлагатай эсэхээ тэмдэглэж, анхдагч шатлалд хийгдсэн эмчилгээ, шинжилгээг амбулаторийн маягтанд дэлгэрэнгүй бичнэ.

13Б-маягтыг эмчлүүлсэн газраас эмнэлэгээс өвчтөн илгээх тохиолдолд олгоно. Хийлгэсэн эмчилгээ, шинжилгээг амбулаторийн маягтанд хавсаргаж явуулна. Бүртгэлийн код нь Эрүүл мэндийн бүртгэлийн маягт АМ-13А маягтын бүртгэлийн кодтой адил байна.

Эрүүл мэндийн маягт АМ-14- Жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэлийг хөтлөх заавар

Уг маягтыг өрхийн болон эмэгтэйчүүдийн хяналтын эмч жирэмсэн эмэгтэйд хөтөлнө. Жирэмсэн эмэгтэй хяналтанд орсон өдрөөс эхлэн жирэмслэлт төгсөж тайланд тусгагдсаны дараа хаагдаж, архивлагдана. АМ-14 маягтыг үндэслэн ЭМТ101.8-10 тайлан гарна.

Жирэмсний хугацаа гэсэн хэсэгт хэрэв шилжиж ирсэн бол тухайн өрхийн эмчийн хяналтанд орох үеийн анхны жирэмсний хугацааг тавина.

Сүүлийн биений юмны хугацаагаар төрөх хугацааг тооцож тавина. Өмнөх төрөлтийн тухай мэдээлэл болон хяналтаас гарсан тухай мэдээллийг эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ӨЭ-1 маягтан дээр байгаа мэдээллээр бүртгэнэ.

Эрүүл мэндийн маягт АМ-15- Жирэмсэн эмэгтэйн хяналтын хөтөч маягтыг *хяналтын эмч болон эх баригч бага эмч хөтлөнө.*
Эрүүл мэндийн маягт АМ-16- Солилцох хуудас бүртгэлийг маягтыг хөтлөх заавар

Өрхийн эмч, эмэгтэйчүүдийн хяналтын эмч жирэмсний 33-34 долоо хоног тээсэн жирэмсэн эхэд олгоно. Солилцох хуудсанд байгаа жирэмслэлттэй холбоотой мэдээллийг эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр ӨЭ-1 маягтаас хуулж авах ба тус маягттай хавсаргаж явуулна.

Уг маягтын А хэсэгт эхийн тухай тодорхой хариулж бичээд, А хэсгийн ар талд шинжилгээний хариу гэсэн хэсэгт жирэмсэн эмэгтэй хяналтанд байх хугацаанд хийсэн шинжилгээ болон биед гарсан өөрчлөлт эмгэгийг бичиж тэмдэглэнэ.

Маягтын Б хэсэгт төрөх тасагт хийгдсэн бүх зүйлийг асуултын дагуу хариулж бичээд төрсөн эхэд өгч гаргах ба өрхийн эмч (хяналтын) хүлээн авч төрсний дараах амралтыг тооцож, уг эмэгтэйн цаашдын жирэмслэлтийг төлөвлөн картанд хавсарган хадгална.

Жирэмсэн эх, солилцох хуудасны А хэсгийг төрөх үедээ харъяаллын төрөх газар авч ирнэ.

Эмнэлгийн ажилтан, жирэмсэн эхийг төрөхөөр ирэх үед солилцох хуудасны А хэсгийг төрөлтийн түүхэнд нааж хавсаргах ба эхийг төрөөд гарах үед маягтын А хэсэг төрөлтийн түүхэнд үлдэнэ.

Маягтын Б хэсэгт төрөх тасагт хийгдсэн бүх зүйлийг асуултын дагуу хариулж бичээд төрсөн эхэд өгч гаргах ба өрхийн эмч (хяналтын) хүлээн авч төрсний дараах амралтыг тооцож, уг эмэгтэйн цаашдын жирэмслэлтийг төлөвлөн картанд хавсарган хадгална.

Эрүүл мэндийн маягт АМ-17- Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг мэдээлэх маягтыг хөтлөх заавар

Эхийн эндэгдэл, ноцтой хүндрэлийг мэдээлэх маягт бөглөх зааварчилгаа

Асуумж	Аргачлал-Тодорхойлолт - Жишээ
Ерөнхий асуулга	Ерөнхий асуулгын зорилго нь эхийн талаарх ерөнхий мэдээллийг үнэн зөв, бодитой цуглуулахад оршино.
Асуулт 1-2: Эхийн нэр	Эхийн иргэний бүртгэлээс баталгаажсан иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн овог, нэрийг тод гаргацтай, татлахгүй, үнэн, зөв бичнэ.
Асуулт 3: Регистрийн дугаар	Эхийн регистрийн дугаарыг бөглөхдөө өвчтний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Регистрийн дугаар гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр, сүүлийн 8 нүдэнд цифрийг тус бүрт гаргацтай бичнэ. *Жишээ: Эхийн регистрийн дугаар* *А Н 8 6 0 2 2 4 6 5*
Асуулт 4: Байнгын оршин суудаг хаяг	Эхийн иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо зэргийг гаргацтай бичнэ.
	Эхийн эрүүл мэндийн асуулга
Асуулт 1: Эхийн жирэмсэн, төрөх, төрсний дараах үе	Жишээ: Эхийн *жирэмсэн,* төрөх, төрсний дараах үед эх хүндэрсэн эсвэл эндсэн эсэхийн аль болохыг сонгож дугуйлна. Эхийн хүндэрсэн болон эндсэн үеийг тодруулахдаа (жирэмсэн, төрөх, төрсний дараах) 1, 44, 45-р асуултууд хоорондоо утгын уялдаатай бөглөгдөхийг анхаарна уу.
Асуулт 2: Эхийн хүндэрсэн, эндсэн газар	Эх хаана хүндэрсэн эсвэл эндсэн болохыг сонгоно. Сонгосон асуултад хариулагдахгүй бол 2.5-ыг дугуйлан, хүндэрсэн эсвэл эндсэн газрыг тодорхой бичнэ.
Асуулт 3: Эхийн нас	Нас гэсэн 2 нүд бүхий хүснэгтэд эхийн төрсөн он, сарыг үндэслэн насыг тооцоолж бүтэн насаар бичнэ. Жишээ: 21 настай эх бол Нас *21* гэж бичнэ.

Асуулт 4: Ам бүл	Ам бүлийн тоог эхийн жирэмсний хяналтын карт, өвчний түүх, төрөлтийн түүхийн паспортын хэсгээс харж үнэн зөв бөглөнө. Жишээ: 3 ам бүлтэй бол *3* гэж бичнэ.
Асуулт 5: Гэр бүлийн байдал	Маягтын кодыг ашиглан гэрлэлтийн байдлыг тэмдэглэнэ. Гэрлэсэн/тусдаа гэдэгт гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй тусдаа амьдарч байгаа хүмүүсийг оруулна. Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч иргэний бүртгэл мэдээллийн төвд бүртгүүлж гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг хамтран амьдрагч гэж кодлоно. Тодорхойгүй гэх хариултыг эхийн ар гэрийн байдлын талаар мэдээлэл авах боломжгүй үед сонгоно.
Асуулт 6: Эхийн боловсрол	Боловсролын түвшинг асуултын кодыг ашиглан тэмдэглэнэ. Боловсролгүй гэдэгт эх ямар нэгэн сургууль төгсөөгүй буюу сургуульд ороогүйг хамааруулна. Тодорхойгүй гэдэг сонголтыг тухайн эхийн боловсролын талаар мэдээлэл авах боломжгүй үед хэрэглэнэ.
Асуулт 7: Нийгмийн байдал	Нийгмийн байдлыг сонгохдоо тохирох хариултын доогуур зурна, дээрх хариултын алинд нь ч орохгүй бол бусад гэсэн хариултын доогуур зурж, тодорхой бичнэ үү.
Асуулт 8: Эхийн эмнэлэгт хэвтсэн хугацаа он, сар, өдөр, цаг, минут	Эхийн эмнэлэгт хэвтсэн хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар нь бичнэ. Үүнийг эхийн өвчний түүх, төрөлтийн түүхээс авч тэмдэглэнэ. *Жишээ: 2014 оны 1 сарын 5-ны 22 цаг 8 минут гэж бичнэ.*
Асуулт 9: Эхийн эмнэлэгт хэвтэх үеийн биеийн байдал	Эхийн эмнэлэгт хэвтэх үеийн биеийн байдалд тохирох хариултын доогуур зурна. Эмэгтэй нь эмч очиход эндсэн эсвэл биеийн байдлыг үнэлэх боломжгүй тохиолдол гарвал бусад гэсэн сонголтыг зурж, хариултыг тодорхой бичнэ.
Асуулт 10: Эмнэлэгт хэвтэх үеийн оношийг	Эмнэлэгт хэвтэх үеийн оношийг хүлээн авсан эмчийн урьдчилсан оношоор (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош) бичнэ. Оношийг гаргацтай бичих ба ӨОУА-10 гэдгийн ард оношийн кодыг бичиж өгнө.
Асуулт 11-13: Эхийн жин, өндөр, цусны даралт	Эхийг хүлээн авсан эмчийн анхны үзлэгийн биеийн жин, өндөр, цусны даралт, судасны цохилтын тоог бичиж тэмдэглэнэ.
Асуулт 14: Хийгдсэн шинжилгээ	Эмнэлэгт хэвтэх үед доорх шинжилгээ *хийгдсэн бол тийм-1, хийгдээгүй бол үгүй-2* гэсэн хариултыг дугуйлна. Дээрх шинжилгээнээс өөр шинжилгээ хийгдсэн байвал бусад гэсэн хэсэгт дэлгэрэнгүй бичиж тэмдэглэнэ.
Асуулт 15: Жирэмслэлтийн тоо	Жирэмслэлтийн тоог бөглөхдөө жирэмсний хяналтын хөтчөөс харж, одоогийн жирэмслэлтийг оролцуулан нийт жирэмслэлтийн тоог бичнэ.
Асуулт 16: Өмнөх төрөлтийн тоо	Өмнөх төрөлтийн тоонд одоогийн жирэмсний төгсгөлийг оруулахгүйгээр нийт хэдэн удаа төрж байсан тоог бичнэ. Ихэр бол нэг төрөлтөнд тооцно. Жирэмсний хяналтын хөтчөөс харж тэмдэглэнэ.

Асуулт 17: Өмнөх жирэмслэлт хэдэн онд байсан бэ?	Энэ жирэмслэлтээс өмнө хэдэн онд жирэмсэлсэн болохыг бичнэ.
Асуулт 18: Өмнөх жирэмсний төгсгөл	Өмнөх жирэмсний төгсгөлийг сонгон дугуйлна.
Асуулт 19: Өмнөх жирэмсэн, төрөлт, төрсний дараа болон үр хөндөлттэй холбоотой ямар нэгэн хүндрэл байсан уу?	Өмнөх жирэмсэн, төрөлт, төрсний дараах болон үр хөндөлттэй холбоотой ямар нэгэн *хүндрэл байсан бол тийм-1, байгаагүй бол үгүй-2* гэж тэмдэглэнэ.
Асуулт 20: Жирэмсний хяналтанд орсон эсэх	Жирэмсний *хяналтанд орсон бол тийм-1, ороогүй бол үгүй-2* гэж тэмдэглэнэ. Түүнчлэн, жирэмсний хяналтанд орсон бол 21-р асуултанд хариулж, цааш үргэлжлүүлэн хариулах ба жирэмсний хяналтанд ороогүй бол 26-р асуулт руу шилжиж, хариулна.
Асуулт 21: Жирэмсний хяналтанд анх орсон хугацаа	Жирэмсний хяналтанд анх орсон хугацааг долоо хоногоор тооцож тэмдэглэнэ. *Жишээ: 8 долоо хоногтой хяналтанд орсон бол 8 гэж тэмдэглэнэ.*
Асуулт 22: Нийт хэдэн удаа үзүүлсэн	Жирэмсний хяналтанд нийт хэдэн удаа үзүүлсэн тоог бичнэ. *Жишээ: 6 удаа хяналтандаа үзүүлсэн бол 6 гэж тэмдэглэнэ.*
Асуулт 23: Жирэмсний хяналтанд байсан газар	Жирэмсний хяналтанд байсан газрыг кодын дагуу сонгоно.
Асуулт 24: Жирэмсний хяналтын эмчийн мэргэжлийн түвшин	Жирэмсний хяналтын эмчийн мэргэжлийн түвшинг кодын дагуу сонгоно.
Асуулт 25: Жирэмсэн үед жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн тухай эрүүл мэндийн хичээл сургалтанд оролцсон эсэх	Жирэмсэн үед жирэмсэн, төрөлт, төрсний дараах үеийн тухай эрүүл мэндийн хичээл сургалтанд *оролцсон бол тийм-1, оролцоогүй бол үгүй-2* гэж тэмдэглэнэ.
Асуулт 26: Энэ жирэмсний үе дэх хавсарсан өвчин	Эхэд жирэмсэнтэй хавсарсан эрхтэн тогтолцооны эмгэг байвал тохирох хариултын кодыг сонгоно. Нэгээс олон хариулт сонгож болно. Эхэд тохиолдсон эрхтэн тогтолцооны эмгэг дээрх хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, эмгэгийн нэрийг тодорхой бичнэ. Мөн халдварт ба шимэгчит зарим өвчин гэсэн хариултыг сонгосон бол тодорхой бичнэ.
Асуулт 27: Одоогийн жирэмсний хүндрэл	Одоогийн жирэмсний явцад тохиолдсон хүндрэлийг тохирох хариултын кодоос сонгоно. Нэгээс олон хариулт сонгож болно. Эхэд тохиолдсон жирэмсний хүндрэл дээрх хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, хүндрэлийг тодорхой бичнэ.

Асуулт 28: Жирэмсэн үед тусламж үзүүлсэн газар	Эхэд жирэмсэн үед тусламж үзүүлсэн газрыг өгөгдсөн кодоос сонгож тэмдэглэнэ. Эхийн жирэмсний хугацаанаас үл харгалзан эх хүндэрч эмнэлэгт хэвтэн эмчлэгдэхэд түүний төрөх хугацаа болоогүй тохиолдолд 28-р асуулт дангаараа, төрсөн бол 29-р асуулт давхар бөглөгдөнө.
Асуулт 29: Эхэд төрөлтийн тусламж үзүүлсэн газар	Эхэд төрөлтийн тусламж үзүүлсэн газрыг өгөгдсөн кодоос сонгож тэмдэглэнэ. Дээрх хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, тодорхой бичнэ.
Асуулт 30: Төрөлт удирдсан хүн	Эхийг төрөх үед төрөлтийг удирдаж төрүүлсэн хүнийг кодын дагуу сонгож тэмдэглэнэ.
Асуулт 31: Эхийн жирэмсний хугацаа (долоо хоногоор)	Эхийн биеийн байдал хүндрэх, нас барах үеийн жирэмсний хугацаа эсвэл төрөх, үр хөндүүлэх үеийн жирэмсний хугацааг долоо хоногоор бичнэ.
Асуулт 32: Одоогийн жирэмсний төгсгөл	Эхийн одоогийн жирэмсний төгсгөлийг өгөгдсөн кодоос сонгоно. Хэрэв эх төрөөгүй бол шалтгааныг дэлгэрэнгүй бичнэ.
Асуулт 33: Төрсөн, үр хөндүүлсэн, зулбасан, мэс засал хийлгэсэн өдөр	Эхийн төрсөн, үр хөндүүлсэн, зулбасан, мэс засал хийлгэсэн эсэхийг доогуур нь зурж, он, сар, өдрийг бичнэ. Жишээ: Эх 2014 оны 3 сарын 16-нд төрсөн бол *Төрсөн*, үр хөндүүлсэн, зулбасан, мэс засал хийлгэсэн: *2014 он 03 сар 16 өдөр* гэж тэмдэглэнэ.
Асуулт 34: Төрөлтийн хэлбэр	Төрөлтийн хэлбэрийг хариултын дагуу кодлож тэмдэглэнэ.
Асуулт 35: Умай агшаах тариа хэрэглэсэн эсэх	Эхийг төрөх үед умай агшаах тариа *хэрэглэсэн бол тийм-1, хэрэглээгүй бол үгүй-2* гэж тэмдэглээд 37-р асуулт руу шилжинэ.
Асуулт 36: Төрөлтийн үед умай агшаах тариаг хэзээ хэрэглэсэн	Умай агшаах тариаг төрөлтийн хэд дүгээр үед хэрэглэснийг өгөгдсөн кодыг ашиглан тэмдэглэнэ. Олон хариулт сонгож болно.
Асуулт 37: Үр хөндөлтийн хэлбэр	Үр хөндөлтийн хэлбэрийг хариултын дагуу кодлож тэмдэглэнэ.
Асуулт 38: Мэс засал хийгдсэн эсэх	Эхэд *мэс засал хийгдсэн бол тийм-1, хийгдээгүй бол үгүй-2* кодыг сонгоно. Хэрэв эхэд мэс засал хийгдээгүй бол 41-р асуултаас эхлэн хариулна.
Асуулт 39: Мэс засал хийх болсон заалт	Эхэд мэс засал хийгдсэн бол мэс заслын заалтыг кодоос сонгож тэмдэглэнэ. Кодолсоноос бусад заалтаар эхэд мэс засал хийгдсэн байвал бусад гэсэн хариултыг сонгож, заалтыг дэлгэрэнгүй бичнэ.
Асуулт 40: Төрөх үеийн мэс ажилбар, мэс заслын тусламж	Эхийг төрөх үед мэс ажилбар, мэс засал хийгдсэн бол кодоос сонгож тэмдэглэнэ. Хэрэв жагсаалтанд байхгүй мэс ажилбар, мэс засал хийгдсэн бол бусад гэсэн кодыг сонгон хариултыг дэлгэрэнгүй бичнэ.
Асуулт 41: Эх цус алдсан эсэх	Эх *цус алдсан бол тийм-1, цус алдаагүй бол үгүй-2* кодыг сонгоно. Тийм хариултыг сонгосон бол 42, 43-р асуултыг бөглөнө. Үгүй хариултыг сонгосон бол 44-р асуулт руу шилжинэ.

Асуулт 42-43: Алдсан, юүлсэн цусны хэмжээ (мл-р)	Эх цус алдсан бол алдсан болон сэлбэсэн цусны хэмжээг мл-ээр бичнэ. Жишээ: 1800 мл цус алдсан, 1200 мл цус юүлсэн бол Алдсан цусны хэмжээ (мл-р): *1800 мл,* Юүлсэн цусны хэмжээ (мл-р): *1200 мл* гэж тэмдэглэнэ.
Асуулт 44: Эхийн ноцтой хүндэрсэн, эндсэн үе	Эхийн ноцтой хүндэрсэн, эндсэн үеийн талаарх мэдээг код ашиглан хариулна. Хэрэв хариултад тохирохгүй бол бусад гэсэн хариултыг сонгож, тодорхой бичнэ.
Асуулт 45: Төрөх, төрсний дараах үеийн хүндрэл	Төрөх, төрсний дараах үеийн хүндрэл тохиолдвол хариултыг кодоос сонгож тэмдэглэнэ. Хэрэв жагсааснаас бусад хүндрэл тохиолдвол бусад гэсэн кодыг сонгож, хүндрэлийг нэрлэж бичнэ.
Асуулт 46: Цус алдалтын шалтгаан	Эхэд цус алдах хүндрэл тохиолдсон бол цус алдсан шалтгааныг тодруулах зорилгоор тохирох хариултын кодыг сонгоно. Хэрэв хариултад тохирохгүй бол бусад гэсэн хариултыг сонгож цус алдалтын шалтгааныг тодорхой бичнэ.
Асуулт 47: Халдвар	Эхэд халдварын хүндрэл тохиолдсон бол халдварын шалтгааныг тодруулах зорилгоор тохирох хариултын кодыг сонгоно. Хэрэв хариултад тохирохгүй бол бусад гэсэн хариултыг сонгож халдварын шалтгааныг тодорхой бичнэ.
Асуулт 48: Эх хүндэрсэн тохиолдолд ямар нэгэн эрхтэн системийн үйл ажиллагааны алдагдал байсан эсэх	Эхэд ямар нэгэн эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал *байсан бол тийм-1, байгаагүй бол үгүй-2* гэсэн кодыг сонгоно. Тийм гэсэн хариулт сонгосон бол 49-р асуултаас эхлэн цааш хариулна. Үгүй гэж хариулсан бол 56-р асуултаас эхлэн хариулна.
Асуулт 49-55: Эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал	Эхэд ямар нэгэн эрхтэн тогтолцооны үйл ажиллагааны алдагдал байсан бол хариултад тохирох кодыг сонгоно уу.
Асуулт 56: Клиникийн төгсгөлийн оношийг (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош)	Клиникийн төгсгөлийн оношийг (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош) дэлгэрэнгүй бичиж оруулахаас гадна ӨОУА-10-аар кодлож бичнэ.
Асуулт 57: Эмнэлгээс гарсан, шилжсэн, нас барсан	Эх эмнэлгээс гарсан, шилжсэн, нас барсан тухай зохих хариултын доогуур зурна. Шилжсэн гэж зурсан бол 58-р асуултанд хариулна.
Асуулт 58: Эмэгтэй дээд шатлалын аль нэг эмнэлэгт шилжсэн	Тухайн эмнэлэгт хүндэрсэн эхийг дээд шатлалын эмнэлэг рүү шилжүүлсэн бол тийм-1, шилжүүлээгүй бол үгүй-2 гэж тэмдэглэнэ.
Асуулт 59: Эмнэлгээс гарсан, шилжсэн эсвэл нас барсан бол хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ	Эх 2013 оны 2 сарын 13-ны 14 цаг 20 минутад эмнэлгээс гарсан бол.... Эмнэлгээс *гарсан,* шилжсэн, нас барсан *2013 он 02 сар 13 өдөр 14 цаг 20 минут* гэж тэмдэглэнэ.
Асуулт 60: Ор хоног	Эх эмнэлгээс гарах, шилжих, нас барах үеийн хугацааг буюу ор хоногийг хоног, цаг, минутаар нь бичнэ. *Жишээ: Ор хоног: 2 хоног 6 цаг 00 минут* гэж тэмдэглэнэ.

Асуулт 61: Эмгэг анатомийн шинжилгээнд орсон эсэх	Эх эндэж эмгэг анатомийн шинжилгээнд *орсон бол орсон-1, ороогүй бол ороогүй-2* гэж хариулаад 65-р асуулт руу шилжинэ.
Асуулт 62: Эмгэг судлалын шинжилгээний онош (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош)	Эмгэг судлалын шинжилгээний оношийг (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош) дэлгэрэнгүй бичиж оруулахаас гадна ӨОУА-10-аар кодлож бичнэ.
Асуулт 63: Онош тохирсон эсэх	Клиникийн онош нь эмгэг судлалын шинжилгээний оноштой тохирсон эсэхийг код ашиглан сонгож тэмдэглэнэ.
Асуулт 64: Тохироогүй бол	Онош тохироогүй бол зөрсөн оношийн төрлөөр сонголт хийнэ.
Асуулт 65: Эх барихын шалтгаантай эсэх	Эхийн ноцтой хүндрэл, эхийн эндэгдэл *эх барихын шууд шалтгаантай бол тийм-1, шууд бус шалтгаантай бол үгүй-2* гэж тэмдэглэнэ.
Асуулт 66: Хожимдол (сонгоно уу)	Эх ноцтой хүндэрсэн эсвэл эндсэн үед хожимдол байсан бол 1, 2, 3-р хожимдлуудын дугаараас сонгон тэмдэглэгээг хийнэ. Нэг эхэд хэдэн ч хожимдол тохиолдсон байж болно.
Асуулт 67: Нярайн хүйс	Нярайн хүйсийг мэдээлэхдээ *хүү бол-1, охин бол-2* гэсэн кодыг сонгоно.
Асуулт 68: Биеийн жин.....гр, өндөр.....см	Нярайг үзсэн эмчийн анхны үзлэгийн биеийн жин, өндрийн хэмжээг бичиж тэмдэглэнэ.
Асуулт 69: Нярайн байдал: амьд, амьгүй, нас барсан (зур)	Нярайн төрөх үеийн байдлыг (амьд, амьгүй, амьд төрөөд нас барсан) тохирох хариултын доогуур зурна.
Асуулт 70: Апгарын үнэлгээ	Амьд төрсөн нярайд Апгарын оноог төрсний дараах 1 минутын байдлаар тэмдэглэнэ.
Асуулт 71: 5 минутын дараах Апгарын үнэлгээ	Амьд төрсөн нярайд Апгарын оноог төрсний дараах 5 минутын байдлаар тэмдэглэнэ.
Асуулт 72: Гэрийн төрөлт бол	Эх гэртээ төрсөн бол эмч дуудсан хугацаа, төрсөн хугацаа, төрөөд эмнэлэгт хэвтүүлсэн хугацаа, эмч очсон хугацаа зэргийг он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ.
Мэдээлсэн: Мэдээлсэн огноо Аймаг/хот Сум/дүүргийн Эмнэлгийн нэр Эмчийн нэр Албан тушаал	*2014* он *04* сар *03* өдөр *12* цаг *20* минут *Аймаг*/хот: *Баян-Өлгий* *Сум*/дүүрэг: *Цэнгэл* Эмнэлгийн нэр: *Цэнгэл сумын эмнэлэг* Эмчийн нэр: *Д.Наран* Албан тушаал: *Эх барих эмэгтэйчүүдийн эмч*

Эрүүл мэндийн маягт АМ-18- Үр хөндөлтийн түүхийн бүртгэлийн маягтыг хөтлөх заавар

Улсын болон хувийн эмнэлэгт үр хөндөх үед хөтөлнө. Үр хөндөлтийг амбулаториор болон стационариор хийсэн аль ч тохиолдолд уг маягтыг бүртгэнэ. Хүндэрсэн тохиолдолд цаас нааж үргэлжлүүлэн бичнэ.

Маягтын асуусан асуултаас гадна зайлшгүй шаардлагатай асуултыг анамнезаар авч тэмдэглэнэ. /Одоогийн үр хөндүүлж буй шалтгааныг /

ҮР ХӨНДӨЛТИЙН БҮРТГЭЛ (АМ-19)

Улсын болон хувийн эмнэлэгт үр хөндсөн тохиолдол бүрд хөтөлнө. Үр хөндүүлсэн эмэгтэйн боловсрол болон нийгмийн байдал гэсэн баганд тухайн хүнд тохирох кодыг бичнэ. Үр хөндөх үед гарсан хүндрэл бүрийг (+)-ээр тэмдэглэнэ.

Эрүүл мэндийн маягт АМ-20 Амбулаториор эмчлүүлэгсдийн картыг их эмч, эх баригч бага эмч хөтлөнө.

Эрүүл мэндийн маягт АМ-21(А-Б) Шинжилгээнд явуулах бичиг, АМ-22(А-М) Лабораторийн шинжилгээний хуудсууд, АМ-23 Лабораторийн шинжилгээний бүртгэл маягтуудыг их эмч, сувилагч, лаборант нар хөтлөнө.

Эрүүл мэндийн маягт АМ-24- Үйл оношийн кабинетийн шинжилгээний бүртгэлийн маягтыг хөтлөх заавар

Энэхүү бүртгэлийг үйл онош зүйн тасаг /ЭХО, рентген, зүрхний болон тархины цахилгаан бичлэг, компьютер гэх мэт/ кабинетуудад хөтөлнө. Эмчлүүлэгч амбулаториор үйлчлүүлж байгаа тохиолдолд уг эмчлүүлэгчийн ЭМД-ын дугаараар төлбөрийн хэлбэр/даатгал, хувиас/ болох даатгалын нэхэмжлэлээр төлөгдөнө. Явуулсан эмчийн оношийг үндэслэн гарсан илэрсэн өөрчлөлт, дүгнэлт хэсэгт онош баталгаажилт буюу гарсан өөрчлөлт онцлогийг тэмдэглэнэ. Мөн рентген зураг болон биопси шинжилгээний өөрчлөлтийг амбулаторын карт АМ-20 маягтанд нааж өөрчлөлтийг дэлгэрэнгүй бичнэ.

Эрүүл мэндийн маягт АМ-25А,Б - Сэргээн засах эмчилгээний карт, бүртгэлийг хөтлөх заавар

Сэргээх эмчилгээний картыг нөхөн сэргээх амбулаторийн тасагт хөтөлнө. Энэхүү картыг мэргэжлийн эмч бусад тасаг нэгжээс илгээсэн эмчийн оношийг үндэслэн өвчтөнд олгох ба эмчилгээний төрөл, аль эрхтэнд ямар хугацаагаар хийх заалтыг дэлгэрэнгүй бичнэ.

Сайжирсан- Эмчилгээний үр дүнд сувилуулагчийн биеийн байдал эмчийн үнэлгээгээр анх эмчилгээ эхэлснээс дээрдсэн тохиолдлыг хэлнэ.

Хэвэндээ- Эмчилгээний хугацаанд сувилуулагчийн биеийн байдал эмчийн үнэлгээгээр анх эмчилгээ эхэлснээс сайжирсан үр дүн гараагүй тохиолдлыг хэлнэ.

Эрүүл мэндийн маягт АМ-25Б- Нөхөн сэргээх эмчилгээний бүртгэлийн маягтыг АМ-25А маягтыг үндэслэн бүртгэл хийж нөхөн сэргээх амбулаторийн тасгийн эмч сувилагч хөтөлнө. Эмчилгээний нэр, төрлөөр ялгаж эмчилгээний төрөл хэсэгт бүртгэл хийх ба 1 өвчтөн хэдэн төрлийн ч эмчилгээний төрөлд хамрагдаж давхардаж бичигдэж болно. Эмч тухайн төрлийн эмчилгээг хэдэн удаа хийх заалтыг “Эмчилгээ хийх удаа” гэсэн хэсэгт бичих ба эмчилгээ хийсэн өдрүүдээр тооцож нийт хийсэн эмчилгээг сувилагч тэмдэглэл хөтөлнө.

Маягтыг загвар маягтын дагуу гаргацтай зөв бичнэ.

Эрүүл мэндийн маягт АМ-26А,Б-Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдагчдын бүртгэлийн маягтыг хөтлөх заавар

Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдагчдын бүртгэлийг Хавдар судлалын үндэсний төвийн хөнгөвчлөх эмчилгээний тасгийн их эмч болон аймаг, дүүргийн хавдрын кабинетийн их эмч, хөнгөвчлөх тусламжийн багийн эмч, хувийн болон буяны хосписуудын их эмч нар ямар нэгэн өвчний хүндрэлийн улмаас хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлсэн өвчтөн бүрт хөтөлнө. Эрүүл мэндийн бүртгэлийн маягт АМ-26А маягтыг амбулаториор болон гэрээр үйлчлүүлсэн тохиолдолд бүртгэнэ. АМ-26Б маягтыг стационараар эмчлүүлэгсдэд хөтөлнө.

Маягтыг загвар маягтын дагуу гаргацтай зөв бичнэ.

Тогтмол хаяг-Өвчтний оршин суугаа хаягийг иргэний үнэмлэхийг үндэслэн дэлгэрэнгүй бичнэ.

Үнэгүй олгосон эм-Тухайн байгууллагаас хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ үзүүлэх үед хэрэглэгдсэн үнэгүй олгох заалттай эмийн хэмжээг бичнэ.

Тайлбар гэсэн хэсэгт онцгой анхаарах дэглэм, хяналтын талаархи мэдээллийг үлдээнэ.

Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдагчдын бүртгэлийг хөтөлсөн эмч, ажилтан уг хуудсыг өөрийн харьяа эрүүл мэндийн байгууллагын статистик мэдээллийн албанд хүлээлгэн өгнө.

Зүү төөнө, засал эмчилгээний карт АМ-29А

Амбулаторт хөтлөгдөх АМ-29А маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Маягтын I талын 1-7 дугаар асуултанд эмчлүүлэгчийн ерөнхий мэдээллийг бичиж тэмдэглэн эмчлэгч эмч гарын үсэг зурж баталгаажуулна. Маягтын II хэсэгт эмчилгээ хийлгэсэн байдал, хэдэн удаа, ямар эмчилгээ хийлгэснийг бичиж тэмдэглэн өдөр бүр эмчилгээ хийсэн эмч гарын үсэг зурж баталгаажуулна. Эмчилгээ дууссаны дараа тухайн эмчлүүлэгчийн биеийн байдал ямар болсон талаар үр дүнгийн хэсэгт доогуур нь зурж бөглөнө.

Дэвтээлгэ засал эмчилгээний засал АМ-29Б

Амбулаторт хөтлөгдөх АМ-29Б маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Эмчлүүлэгчийн нэр, нас, хүйс, эмчилгээ эхэлсэн он сар болон дууссан он сарыг бичиж тэмдэглэн, үндсэн оношийг тавьж, эмчилгээний төрлийг сонгон гарын үсэг зурж баталгаажуулна.

Бариа засал эмчилгээний карт АМ-29В

Бариа засал эмчилгээний карт АМ-29В маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Маягтын I хэсэгт эмчлүүлэгчийн нэр, нас, хүйс, эмчилгээ эхэлсэн он сар болон дууссан он сарыг бичиж тэмдэглэн, үндсэн оношийг тавьж, барианы төрөл, хэсэгчилсэн барианы төрлийг тэмдэглэж гарын үсэг зурж баталгаажуулна. Маягтын II хэсэгт барианы төрөл, он, сар, өдөр,

ямар эрхтэнд хийгдэж байгаа, хэдэн удаа, нэг удаа хийхэд үргэлжилсэн хугацааг тэмдэглэж гарын үсэг зурж баталгаажуулна.

Хатгах засал эмчилгээний карт АМ-29Г

Хатгах засал эмчилгээний карт АМ-29Г эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэр, кодыг асуултын харгалзах хэсэгт бөглөнө. Өвчтөний ерөнхий мэдээлэл овог, нэр, нас, хүйсийг тэмдэглэнэ. Эмчилгээ эхэлсэн болон дуусан он сарыг тэмдэглэнэ. Үндсэн оношыг ӨОУА-10-аар бичиж тэмдэглэнэ. Эмчилгээний төрөл, талбай, байрлалыг харгалзах хэсэгт бичнэ. Хүндрэл гарсан тохиолдолд гарсан хүндрэл хэсэгт бичиж тэмдэглэнэ. Өвчтөн хатгах засал хийхийг зөвшөөрсөн бол өвчтөний нэр хэсэгт өвчтөний нэрийг бичиж баталгаажуулна. Эмчилгээ хийсэн их эмч мөн овог, нэр тавьж баталгаажуулна.

Настны эрүүл мэндийн бүртгэл АМ-28 маягт

Настанд эрүүл мэндийн анхан шатны байгууллага болох өрх, сумын эрүүл мэндийн төв өөрийн харъяалалд оршин суудаг 55, түүнээс дээш насны эмэгтэй, 60, түүнээс дээш насны эрэгтэйг хамруулна. АМ-28 маягтыг үндэслэн ЭМТ 101.6.1-2 тайлнгууд гарна.

Настны өдөр тутмын бие даах чадварын болон багаж хэрэгсэлтэй ажиллах чадвар үнэлгээг Эрүүл мэндийн Сайдын 2010 оны 5 дугаар сарын 31-ны 180 тоот тушаалаар батлагдсан “Настны эрүүл мэндийн үнэлгээний удирдамж”-аар батлагдсан сорилуудаар үнэлнэ.

Настны өдөр тутмын бие даах чадварын үнэлгээ: 10-12 оноо-хэвийн, 6-9 оноо –алдагдсан, 0-5 оноо- хараат гэж тодорхойлно.

Настны багаж хэрэгсэлтэй ажиллах чадварын үнэлгээ: 14-16 оноо –хэвийн, 10-13 оноо –алдагдсан, 6-9 оноо-хараат гэж тодорхойлно.

Настны танин мэдэхүйн чадварыг үнэлэх хураангуй сорил: Хэвийн-24-30 оноо, үл мэдэг танин мэдэхүйн чадвар буурсан 23-18 оноо, хүнд хэлбэрээр танин мэдэхүйн чадвар буурсан-17 оноо гэж тодорхойлно.

Хоол тэжээлийн байдлыг үнэлэх хураангуйлсан асуумж: 12-14 оноо-хоол тэжээлийн байдал хэвийн, 8-11 оноо-хоол тэжээлийн дуталд хүрэх эрсдэлтэй, 0-7 оноо-хоол тэжээлийн дуталтай

Биеийн жингийн индекс: Эмч настны биеийн жингийн индексийг тооцоод 18.5-24кг/м.кв-туранхай-, Хэвийн -18.5-24кг/м.кв, Илүүдэл жинтэй-25-29кг/м.кв, Тарган-30кг/м.кв< гэж тодорхойлно.

Эрүүл мэндийн бүлэг: Настны эрүүл мэндийн байдлыг тодорхойлж ЭМТ-101.1 маягтад тодорхойлсны дагуу тооцож гаргана.

Сэтгэцийн болон зан төрхийн эмгэг: Настанд өвчний олон улсын 10-р ангиллын 5-р бүлэгт хамаарах өвчин эмгэг бүртгэгдсэн тохиолдолд бичнэ.

Насны доройтол: Настанд өвчний олон улсын 10-р ангиллын R54 кодод хамаарагдах шинж тэмдэг илэрсэн тохиолдолд бичнэ.

Зүү төөнө, засал эмчилгээний карт АМ29А, Дэвтээлгэ засал эмчилгээний карт АМ-29Б, Бариа засал эмчилгээний карт АМ29В, Хатгах засал эмчилгээний карт АМ29Г маягт

Зүү төөнө, засал эмчилгээний карт АМ-29А

Амбулаторит хөтлөгдөх АМ-29А маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Маягтын I талын 1-7 дугаар асуултанд эмчлүүлэгчийн ерөнхий мэдээллийг бичиж тэмдэглэн эмчлэгч эмч гарын үсэг зурж баталгаажуулна. Маягтын II хэсэгт эмчилгээ хийлгэсэн байдал, хэдэн удаа, ямар эмчилгээ хийлгэснийг бичиж тэмдэглэн өдөр бүр эмчилгээ хийсэн эмч гарын үсэг зурж баталгаажуулна. Эмчилгээ дууссаны дараа тухайн эмчлүүлэгчийн биеийн байдал ямар болсон талаар үр дүнгийн хэсэгт доогуур нь зурж бөглөнө.

Дэвтээлгэ засал эмчилгээни засал АМ-29Б

Амбулаторит хөтлөгдөх АМ-29Б маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Эмчлүүлэгчийн нэр, нас, хүйс, эмчилгээ эхэлсэн он сар болон дууссан он сарыг бичиж тэмдэглэн, үндсэн оношийг тавьж, эмчилгээний төрлийг сонгон гарын үсэг зурж баталгаажуулна.

Дэвтээлгэ засал гэдэг нь биеийн гадна талаас байгаль, амьтан ургамлын гаралтай зүйлийг ашиглан орох, шавших, түрхэх, ороож боох, утах зэргээр өвчнийг анагаадаг уламжлалт зөөлөн заслын нэг төрөл юм.

Бариа засал эмчилгээний карт АМ-29В

Бариа засал эмчилгээний карт АМ-29В маягтыг эмчилгээ үзүүлж буй их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэрний хэсэгт тухайн эрүүл мэндийн байгууллага нэр, кодоор бичиж тэмдэглэнэ. Маягтын I хэсэгт эмчлүүлэгчийн нэр, нас, хүйс, эмчилгээ эхэлсэн он сар болон дууссан он сарыг бичиж тэмдэглэн, үндсэн оношийг тавьж, барианы төрөл, хэсэгчилсэн барианы төрлийг тэмдэглэж гарын үсэг зурж баталгаажуулна. Маягтын II хэсэгт барианы төрөл, он, сар, өдөр, ямар эрхтэнд хийгдэж байгаа, хэдэн удаа, нэг удаа хийхэд үргэлжилсэн хугацааг тэмдэглэж гарын үсэг зурж баталгаажуулна.

Хатгах засал эмчилгээний карт АМ-29Г

Хатгах засал эмчилгээний карт АМ-29Г эмчилгээ хийсэн их эмч хөтөлнө. Эмнэлгийн нэр, кодыг асуултын харгалзах хэсэгт бөглөнө. Өвчтөний ерөнхий мэдээлэл овог, нэр, нас, хүйсийг тэмдэглэнэ. Эмчилгээ эхэлсэн болон дууссан он сарыг тэмдэглэнэ. Үндсэн оношыг /ӨОУА-10/-аар бичиж тэмдэглэнэ. Эмчилгээний төрөл, талбай, байрлалыг харгалзах хэсэгт бичнэ. Хүндрэл гарсан тохиолдолд гарсан хүндрэл хэсэгт бичиж тэмдэглэнэ. Өвчтөн хатгах засал хийхийг зөвшөөрсөн бол өвчтөний нэр хэсэгт өвчтөний нэрийг бичиж баталгаажуулна. Эмчилгээ хийсэн их эмч мөн овог, нэр тавьж баталгаажуулна.

Халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийн маягтууд
Эрүүл мэндийн сайдын 2012 оны 3 сарын 29-ний өдрийн 95 тоот тушаалын дагуу үзлэгийг хийж бүртгэлийг маягтын дагуу их эмч хөтлөнө.
“Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгийн маягт” ХБӨЭИМ-1
“Чихрийн шижин хэв шинж 2 өвчний эрт илрүүлгийн үзлэгийн маягт” ХБӨЭИМ-2

“Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгийн маягт” СМУ-2, “Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгийн маягт” СМХ -2 Анхдаг шатлалын эрүүл мэндийн байгууллагуудад эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулан хийж байгаа бөгөөд 450 дугаар тушаалаар шинээр батлагдсан.

Осол гэмтлийн өвчлөл, нас баралттай холбоотой нэр томьёо

1. *Осол гэмтэл*
   Гадны хүчин зүйлийн урт болон богино хугацааны үйлчлэл, нөлөөллөөр хүний бие махбодын бүтэц, үйл ажиллагаа, эрүүл мэндэд учрах хохирол буюу эмгэгшлийг хэлнэ. Гадны хүчин зүйл нь механик, туяа, халуун, хүйтэн, гэрэл, цахилгаан, даралт буюу физикийн, химийн гэх мэт олон төрлөөс бүрдэнэ. Осол гэмтлийг түүний үйлдсэн хэлбэрээр нь санамсаргүй болон санаатай тохиолдол гэж ангилдаг.

2. *Осол гэмтлийн шинэ тохиолдол*
   Тухайн тайлангийн жилд тухайн осол гэмтлийн шалтгаанаар эмнэлэгт анх удаа хандаж тусламж авсан болон эмнэлэгт тусламж авч чадалгүй газар дээрээ нас барсан тохиолдлыг хэлнэ. Хэрэв тухайн хүн тухайн тайлангийн жилд дахин өөр шалтгаанаар шинэ осол гэмтэлд өртсөн бол мөн шинэ тохиолдлоор бүртгэнэ.
   Осол гэмтлийн шалтгаант нас баралт нь осол гэмтлийн шинэ тохиолдол мөн бөгөөд тухайн гэмтлийн улмаас аль 1 эрүүл мэндийн байгууллагад бүртгэгдээгүй бол түүнийг шинэ тохиолдлоор бүртгэнэ. Жишээ нь: зам тээврийн ослын үед машинд 5 хүн байсны 2 нь нас барсан, 3 нь гэмтсэн бол 5-уулаа шинэ тохиолдолд бүртгэгдэнэ.

3. *Нэг удаагийн тохиолдол*
   Гэмтсэн хүн бүрийг тусад нь бүртгэх ба жишээ нь нэг удаагийн зам тээврийн ослоор хамт гэмтсэн гурван хүнийг гурван тохиолдолд бүртгэнэ.

4. *Санамсаргүй осол гэмтэл*
   Санамсаргүй осол гэмтэл гэж зориудын бус, болгоомжгүй үйлдлээс үүссэн осол гэмтлийн тохиолдлыг хэлнэ. Тухайлбал: Зам тээврийн осол, халитарч унах, гал түймэр, хордлого, живэх, бүтэх гэх мэт
   4.1. Зам тээврийн осол
   Нийтийн зам, харгуй дээр тээврийн хэрэгслийн оролцоотойгоор гарах гэмтэл, золгүй тохиолдлыг зам тээврийн осол гэнэ. (ДЭМБ)
   4.2. Түлэгдэлт
   Түлэгдэлт буюу дулааны өндөр хэмээс шалтгаалах осол гэмтэл гэдэг нь халуун шингэн (шалзлах), халуун хатуу биет (хавьталтын түлэгдэлт) эсвэл галын (галын түлэгдэлт) улмаас хүний арьсны бүх эсвэл аль нэг давхрагын эд эс гэмтэхийг хэлдэг. Мөн хэт ягаан туяа, цацраг, цахилгаан, химийн бодис, хорт бодисоор амьсгалснаас шалтгаалж, уушиг гэмтэх зэргийг түлэгдэлтэд оруулна.
   4.3. Живэх
   Живэлт гэж шингэн зүйл амьсгалын замын бүх эсвэл аль нэг хэсэгт орохыг хэлнэ.

   4.4. Унах

Уналт гэдэг нь хүн газарт, шалан дээр зэрэг ижил түвшинд эсвэл аль нэг түвшнээс доош унаж, бэртэхийг хэлнэ.

4.5. Хордох

Хордолт гэж хорт бодисын нөлөөгөөр үүсэж байгаа үйл ажиллагааны өөрчлөлтийг хэлнэ.

5. *Санаатай үйлдэгдсэн осол гэмтэл*

Зориудаар бусдын болон өөрийнхөө биед халдах, хүчирхийлэх, амь насыг хохироох, амиа хорлох зорилгоор үйлдэгдсэн осол гэмтлийг хэлнэ.

Үүнд: хүн хоорондын зодоон, аллага, халдлага, бэлгийн хүчирхийлэл, амиа хорлох болон амиа хорлохыг завдах оролдлогууд орно. Сэдэл нь санаатайгаар үйлдэгдсэн байна.

5.1. Хүчирхийлэл

Биеийн хүч болон бусад давуу байдлаа зориудаар ашиглан бусдыг айлган сүрдүүлэх, бодит байдлаар хүчирхийлэх, нийгэм болон хэсэг бүлэгт эрүүл мэнд болон сэтгэл санааны хор хохирол, гэмтэл учруулах, хоцрогдол, үгүйрэл, хоосрол, үхэл зэргийг үүсгэх ба үүсгэхийг завдахыг хэлнэ.

5.2. Бэлгийн хүчирхийлэл

Тухайн эрэгтэй болон эмэгтэйн хүслийг харгалзахгүйгээр биеийн хүчээр бэлгийн харьцаанд орохыг шаардах, бэлгийн ажил хийх болон бэлгийн ажил хийхийг завдахыг бэлгийн хүчирхийлэл гэнэ. Үүнд тухайн нөхцөл байдлыг ойлгох чадваргүй хүн, бэлгийн харьцаанд орохыг татгалзсан хүн, бэлгийн харьцааг хүсэхгүй (өвчтэй, тахир дутуу, эмийн болон архины нөлөөнд байгаа, айж сүрдсэн шахалт дарамтанд орсны улмаас) хүнтэй бэлгийн харьцаанд орох болон оролдлого хийхийг хамруулна.

5.3. Алан хядах үйл ажиллагаа

Хууль бус байдлаар, хүчээр хувь хүн болон эд хөрөнгийн эсрэг айлган сүрдүүлэх, хүчлэн албадах, энгийн ард иргэд, хүн амын тодорхой хэсэг бүлгийн эсрэг тодорхой зорилгоор хийх хүчирхийллийг хэлнэ.

5.4. Өөрийгөө гэмтээх

Зориудаар өөрийн эрүүл мэнд, бие махбодод хор хохирол учруулсан болон учруулахыг завдсан үйлдлийг хэлнэ.

5.5. Амиа хорлох

Гэмтээх, хордуулах, боймлох зэргээр тухайн этгээд өөрийнхөө үхэх зорилгыг илэрхий байдлаар эсвэл далд хэлбэрээр ямар нэгэн нотолгоотойгоор үйлдэхийг хэлнэ.

5.6. Амиа хорлох оролдлого

Өөрийгөө гэмтээх, хөнөөх үйлдлийг илэрхий болон далд хэлбэрээр тодорхой түвшинд гүйцэтгэж, үхэлд хүрэлгүйгээр амиа хорлохыг завдсан оролдлогыг хэлнэ. Олон улсын ангиллаар амиа хорлоход галт зэвсэг, өндрөөс зориудаар унах, өөрийгөө дүүжлэх, эмийн болон химийн бодисыг хэрэглэх зэрэг үйлдлээр өөрийгөө егүүтгэх оролдлогууд хамаарна.

Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас АМ-33

ЕРӨНХИЙ ЗААВАР:

1. Осол гэмтлийн улмаас эмнэлэгт үзүүлсэн шинэ тохиолдол бүрт энэхүү “Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудсыг хөтлөх буюу давтан үзлэгт уг маягтыг бөглөхгүй.

2. Ижил гэмтлээс давтан ирэх тохиолдлыг давхар бүртгэхгүй бөгөөд жишээ нь түлэгдсэн хүн эмчилгээнд давтан ирэх тохиолдолд шинээр тандалтын хуудас бөглөх ёсгүй. Ямарваа нэг хүний шинэ гэмтлийг шинэ тохиолдолд бүртгэх ба жишээ нь өвчтөн эхний долоо хоногт өндрөөс унах, дараагийн долоо хоногт нохойд хазуулсан тохиолдолд тус тусад нь шинэ тохиолдолд тооцно.
3. Хэрэв нэг хүн осол гэмтлийн 2 шалтгаанаар гэмтсэн бол үндсэн шалтгааныг нь л бөглөх буюу Б-2 дээр давхцуулж бичихгүй.
    1. Жишээ нь: хэн нэгэн хүн галаар түлж гэмтээсэн бол Б-2-ийн хүчирхийлэл гэсэн шалтгааныг бөглөөд Г7 дээр / галаар түлэх/ ашигласан зүйлсийг тэмдэглэнэ.
4. Маягтыг бөглөхдөө асуултын дагуух харалдаа хэсэгт байгаа номерийг чагтлах буюу дугуйлан зурж тэмдэглэнэ.

   Эмчийн зурж тэмдэглэсэн шифрийг шууд компьютерт шивж оруулах тул асуумж бүрийг алгасалгүй бөглөсөн байх ёстой.
5. Маягтуудыг өдөр тутам статистикч бага эмч нар хянаж, бүрэн бөглөгдөөгүй тохиолдолд тухайн маягтыг бөглөсөн эмчид эргэн хандаж бөглүүлнэ.
6. Энэхүү маягтын асуумж бүр дээр байгаа бусад гэсэн нүдийг бөглөх тохиолдолд заавал тодорхой бичнэ.
7. Зам тээврийн осол, хүчирхийлэл, амиа хорлохыг завдсанаас бусад шалтгаантай осол гэмтэлд өртсөн бол Б-2 хэсэг дээр аль шалтгаан нь гэдгийг сонгож бөглөөд харин В, Г, Д хэсгийг бөглөхгүй.
8. Энэхүү маягтын В хэсгийг зам тээврийн осолд өртсөн тохиолдолд л бөглөх буюу энэ тохиолдолд Г, Д хэсгийг бөглөхгүй.
9. Маягтын Г хэсгийг хүчирхийлэлд өртсөн тохиолдолд л бөглөх буюу энэ тохиолдолд В, Д хэсгийг бөглөхгүй.
10. Маягтын Д хэсгийг амиа хорлохыг завдсан тохиолдолд л бөглөх буюу энэ тохиолдолд В, Г хэсгийг бөглөхгүй.

АСУУМЖИЙГ ХӨТЛӨХ ЗААВАР:

”Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас”-ыг үзлэг хийсэн эмч осол гэмтлийн **<u>шинэ тохиолдол</u>** бүрт хөтөлнө. Өвчтний биеийн байдалд тохируулан эрэмбэлэн ангиллын А, В, С, D зэргийн аль нэгийг сонгон дугуйлна.

А. Паспортын хэсэг	
Асуумж	Тодорхойлолт, жишээ:
А1. Эмнэлгийн нэр	Эмнэлгийн нэрийг бичихдээ эмнэлгийн нэр гэсэн 6 нүдний эхний 2 нүдэнд аймаг хотын, дараагийн 2 нүдэнд сум, дүүргийн, сүүлийн 2 нүдэнд эмнэлгийн шифрийг тус тус бичнэ. Жишээ нь: Баянхонгор аймгийн Галуут сумын эмнэлэг 0 3 1 1 0 3

А2. Эцэг /эх/-ийн нэр	Осол гэмтэлд өртсөн хүний эцэг /эх/ -ийн нэрийг бичнэ
А3. Нэр	Осол гэмтэлд өртсөн хүний өөрийн нэрийг бичнэ.
А4. Регистрийн дугаар	Гэмтсэн хүний регистрийн дугаарыг бичих ба хүснэгтийн эхний 2 нүдэнд үсэг, дараагийн 8 нүд тус бүрт нэг цифр байхаар тохируулж бичнэ.
Асуулт 4: Хэд дэх төрөлт	Энэ төрөлт эхийн хэд дэх төрөлт болохыг өгөгдсөн кодоос сонгоно. Анх удаагаа төрж байгаа бол 1 дэх буюу 1 гэсэн кодыг, 2, 3, 4 дэх төрөлт бол 2-4 буюу 2 гэсэн кодыг 5 ба түүнээс дээшхи төрөлт бол 5 ба түүнээс дээш буюу 3 гэсэн кодыг, төрөлтийн талаар мэдээлэлгүй бол мэдээлэлгүй буюу 4 гэсэн кодыг сонгоно.
Асуулт 5: Өмнөх жирэмслэлтийн төгсгөл	Өмнөх жирэмслэлтийн тоог бичихдээ өмнө нь хэдэн удаа амьд хүүхэд төрүүлж байсан, хэдэн удаа амьгүй хүүхэд төрүүлж байсан, хэдэн удаа зулбаж, үр хөндүүлж байсан, хэдэн удаа өсөлтгүй, умайн гадуур жирэмсэлж байсан зэргийг тоогоор бичнэ. *Жишээ: 1. Зулбалт* [2] *2. Үр хөндөлт* [0] *3. Өсөлтгүй жирэмсэн* [1] *4. Умайн гаднах жирэмсэн* [0] *5. Амьгүй төрөлт* [0] *6. Амьд төрөлт* [2]
	В. Нярайн талаарх мэдээлэл
Асуулт 1: Хүүхдийн төрсөн он, сар, өдөр	Нярайн төрсөн он, сар, өдрийг тодорхой бичнэ. *Жишээ: Нярай 2014 он 3 сар 16 өдөр* гэж тэмдэглэнэ.
Асуулт 2: Төрөх үеийн тээлтийн нас	Нярайн төрөх үеийн тээлтийн насыг долоо хоног, хоногоор бичнэ. Тээлтийн насыг сүүлийн сарын тэмдгийн эхний өдрөөс эхлэн тооцно. *Жишээ:* [3 8] *долоо хоног* [3] *хоног*
Асуулт 3: Төрөх үеийн жин	Нярайг үзсэн эмчийн анхны үзлэгийн биеийн жинг бичиж тэмдэглэнэ.
Асуулт 4: Хүйс	Нярайн хүйсийг *эр-1, эм-2* гэж дугуйлна. Хүйс *тодорхойгүй бол-3, мэдээлэлгүй бол-4* гэж сонгоно.
Асуулт 5: Хүүхэд ихэр эсэх:	Энэ төрөлтөөр ихэр хүүхэд төрсөн эсэхийг тийм-1, үгүй-2 гэж сонгоно. Ихэр хүүхэд төрсөн бол хэдэн ихэр төрснийг кодоос сонгоно: *2 ихэр бол-1, 3 ба түүнээс олон ихэр бол-2, хэдэн ихэр төрсөн талаар мэдээлэлгүй бол 3 гэж сонгоно.* Ихэр хүүхэд төрсөн бол асуулт 6-д хариулна. Ихэр төрөөгүй бол асуулт 7 руу шилжинэ.
Асуулт 6: Ихэр хүүхэд бол хэдэн хүүхдэд нь гажиг илэрсэн бэ?	Ихэр хүүхдийн хэдэн хүүхэд нь төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн болохыг өгөгдсөн кодоос сонгоно.
Асуулт 7: Хүүхэд амьдарсан эсэх	Төрөлхийн хөгжлийн гажигтай хүүхэд *амьдарсан бол тийм-1, эндсэн бол үгүй-2* сонгоно. Эндсэн бол асуулт 8 руу шилжинэ. Хүүхэд амьдарсан бол асуулт 8-ыг алгасна.
Асуулт 8: Үгүй бол хүүхэд эндсэн нас	Хүүхэд эндэх үеийн насыг хоног цаг минутаар бичнэ. *Жишээ: Хоног 0 3 цаг 1* [3] *минут* [2 0] [ ]
	Г. Оношилгоо
Асуулт 1: Оношилогдсон хугацаа	Төрөлхийн хөгжлийн гажиг анх оношилогдсон хугацааг тохирох кодоос сонгоно. Эхийн умайд пренаталь оношилгоогоор оношилогдсон бол асуулт 2, 3-т хариулна. Төрөх үед, төрсний дараа оношилогдсон бол асуулт 5 руу шилжинэ.
Асуулт 2: Пренаталь оношилгоогоор хөгжлийн	Пренаталь оношилгоогоор ургийн гажиг оношилогдох үеийн ургийн насыг долоо хоног, хоногоор бичнэ.

гажиг оношилогдох үеийн ургийн нас	
Асуулт 3: Пренаталь оношилгооны шинжилгээгээр анх илэрсэн бол	Пренаталь оношилгооны шинжилгээнд эхогоор оношилогдсон бол жирэмсний ямар хугацаанд оношилогдсоныг тохирох кодоос сонгоно. Эхоноос бусад шинжилгээгээр оношилогдсон бол бусад гэсэн кодыг сонгож ямар шинжилгээ болохыг дэлгэрэнгүй бичнэ.
Асуулт 4: Задлан шинжилгээгээр оношилогдсон эсэх	Задлан шинжилгээгээр анх *оношилогдсон бол тийм-1, оношилогдоогүй бол үгүй-2* кодыг дугуйлна. Тийм кодыг сонгосон бол оношилгоо хэсгийн асуулт 1, 2, 3-ыг бөглөхгүй орхино.
Асуулт 5: Оношилогдсон гажиг мэс заслын аргаар эмчлэгдэх боломжтой эсэх	Тухайн гажиг мэс заслын аргаар эмчлэгдэх боломжтой эсэхийг тохирох кодоос сонгоно. Эмчлэгдэх *боломжтой бол тийм-1, эмчлэгдэх боломжгүй бол үгүй-2* гэж сонгоно.
Асуулт 6: Нярайд илэрсэн төрөлхийн хөгжлийн гажгийн хэлбэрийг эрхтэн, тогтолцоогоор нэг бүрчлэн оношийг бичнэ үү	Тухайн нярайд илэрсэн гажгийг эрхтэн тогтолцоо тус бүрээр дэлгэрэнгүй тоочиж бичнэ. Төрөлхийн бодисын солилцооны эмгэг байвал бусад төрөлхийн гажиг гэдэгт оношийг бичнэ.
Асуулт 7: Хүүхдийн зураг, лабораторийн ба дүрс оношилгооны нэмэлт материал дагалдсан эсэх	Хүүхдийн төрөлхийн хөгжлийн гажиг гэсэн оношийг батлах хүүхдийн зураг, шинжилгээ, оношилгооны нэмэлт материалыг маягтын хамт хавсарган *явуулсан бол тийм-1, явуулаагүй бол үгүй-2* гэж дугуйлна.
Асуулт 8: Нярай ба ургийн кариотип тодорхойлох шинжилгээ хийсэн эсэх	Хромосомын гажиг байгаа тохиолдолд хромосомын гажгийг батлах кариотипийн шинжилгээ *хийсэн бол тийм-1, хийгээгүй бол үгүй-2* гэж сонгоно. Кариотипийн шинжилгээ хийсэн бол тухайн кариотипийг тохирох зайд бичиж тэмдэглэнэ.
	Д. Нөлөөлөх хүчин зүйл
Асуулт 1: Цусан төрлийн гэрлэлт	Эцэг, эх нь хоорондоо цусан төрлийн хамаатан эсэхийг кодоос сонгож дугуйлна.
Асуулт 2: Эцгийн нас	Эцгийн нас гэсэн 2 нүд бүхий хүснэгтэд эцгийн төрсөн оныг үндэслэн насыг тооцоолж бүтэн насаар бичнэ. Жишээ: 1980 онд эцэг нь төрсөн байвал 2014 оноос 1980-г хасаж 34 гэж тооцож 3 4 бичнэ.
Асуулт 3: Эцгийн эрхэлсэн ажил	Эцгийн эрхэлдэг ажлыг сонгохдоо тохирох хариултыг дугуйлна. Дээрх хариултын алинд нь ч орохгүй бол бусад гэсэн хариултыг дугуйлаад тодорхой бичнэ.
Асуулт 4: Эхийн боловсрол	Эхийн сурч төгссөн боловсролын хамгийн дээд зэргийг сонгоно. Сурч байгаагүй бол боловсролгүй, боловсролын талаар мэдээлэлгүй бол 6 гэсэн кодыг сонгоно.
Асуулт 5: Эхийн эрхэлсэн ажил	Эхийн эрхэлдэг ажлыг сонгохдоо тохирох хариултыг дугуйлна. Дээрх хариултын алинд нь ч орохгүй бол бусад гэсэн хариултыг дугуйлаад тодорхой бичнэ.
Асуулт 6: Эх нь жирэмсний эхний 16 долоо хоногийн дотор тамхи татсан эсэх	Эх жирэмсний эхний 16 долоо хоног буюу жирэмсний эхний 4 сар дотор *тамхи татсан бол тийм-1, тамхи татаагүй бол үгүй-2* кодыг дугуйлна. Тамхи татсан бол өдөрт татсан тамхины тоог ширхэгээр сонгож дугуйлна.
Асуулт 7: Ойр дотны хамт амьдардаг хүмүүс нь эхийн	Ойр дотны, хамт амьдардаг хүмүүс эхийн жирэмсний эхний 16 долоо хоног буюу жирэмсний эхний 4 сарын дотор *тамхи татсан*

жирэмсний эхний 16 долоо хоногийн дотор дэргэд нь тамхи татсан эсэх	*бол тийм-1, татаагүй бол үгүй-2* гэсэн кодыг дугуйлна (Өөрөөр хэлбэл дам тамхидалтад өртсөн бол). Дэргэд нь хүн тамхи татаж байсан талаар мэдээлэлгүй бол мэдэхгүй-3 гэсэн кодыг сонгоно. Тийм гэсэн кодыг сонгосон бол өдөрт хэдэн ширхэг тамхи дэргэд нь татаж байсан тоог сонгоно.
Асуулт 8: Эх нь жирэмсний эхний 16 долоо хоногийн дотор архи уусан эсэх	Эх нь жирэмсний эхний 16 долоо хоног буюу жирэмсний эхний 4 сар дотор *архи уусан бол тийм-1, уугаагүй бол үгүй-2* гэсэн кодыг сонгоно. Архи уусан талаар мэдээлэлгүй бол-3 гэсэн кодыг сонгоно. Эхийн уусан архины хэмжээг тогтоохдоо 1 удаад 50 мл архи, 500 мл шар айраг, 200 мл дарс, 120 мл ликёр эсвэл 300 мл айргийн аль нэгийг уусан бол дунд зэрэг гэж үзнэ. Энэ хэмжээнээс бага уусан бол бага зэрэг, их уусан бол их гэж сонгож тэмдэглэнэ.
Асуулт 9: Эх нь архаг эмгэгтэй эсэх	Эхэд архаг эмгэг (Чихрийн шижин өвчин, эпилепси, халдвар зэрэг) байгаа эсэхийг тохирох кодоос сонгоно. Архаг эмгэг байгаа бол асуулт 10-т хариулна. Архаг эмгэг байхгүй бол асуулт 11 рүү шилжинэ.
Асуулт 10: Хэрэв дээрх өвчний улмаас эмчилгээ хийлгэсэн бол эмийг бичнэ үү	Энэ жирэмсний үед эх архаг эмгэгийн улмаас эмчилгээ хийлгэж байсан бол эмийг нэрлэж бичнэ.
Асуулт 11-13: Жирэмсний эхний 16 долоо хоног дотор эх халуурсан, 38өС-аас дээш халуурсан, халдварт өвчин туссан эсэх	Жирэмсний эхний 16 долоо хоног буюу жирэмсний эхний 4 сар дотор халуурсан бол тийм-1, халуураагүй бол үгүй-2 гэсэн кодыг сонгоно. Халуурсан талаар мэдээлэлгүй бол-3 гэж сонгоно. Халуурсан бол асуулт 12 руу шилжиж, 38°С-аас өндөр халуурсан эсэхийг сонгоно. Мөн халуурсан бол асуулт 13 руу шилжиж, халдварт өвчний шалтгаантай эсэхийг сонгоно. Халуураагүй бол асуулт 14 рүү шилжинэ.
Асуулт 14: Жирэмсний эхний 16 долоо хоногт архаг эмгэгээс бусад өвчний үед эм хэрэглэсэн эсэх	Эх жирэмсний эхний 16 долоо хоног буюу жирэмсний эхний 4 сар дотор архаг эмгэгээс бусад шалтгаанаар эм хэрэглэсэн бол тохирох кодоос сонгож, ямар эм болохыг тоочиж бичнэ.
Асуулт 15: Жирэмсний эхний 16 долоо хоногт цус алдсан эсэх	Эх жирэмсний эхний 16 долоо хоног буюу жирэмсний эхний 4 сар дотор тодорхой хэмжээгээр цус алдаж байсан эсэхийг тохирох хариултаас сонгоно. Цус алдаж байсан талаар мэдээлэл байхгүй бол мэдээлэлгүй-3 гэсэн кодыг сонгоно.
Асуулт 16: Жирэмсний эхний 16 долоо хоногт рентгенд харуулсан эсэх	Эх жирэмсний эхний 16 долоо хоног буюу жирэмсний эхний 4 сар дотор рентгенд харуулсан бол тийм-1, харуулаагүй бол үгүй-2 гэсэн кодыг сонгоно. Рентгенд харуулсан бол биеийн аль хэсгийг харуулснаа тоочиж бичнэ.
Асуулт 17: Үргүйдлийн эмчилгээ хийлгэсэн эсэх	Эх үргүйдлийн эмчилгээ хийлгэж байсан эсэхийг тохирох кодоос сонгоно. Эмчилгээ хийлгэж байсан бол тийм-1, хийлгэж байгаагүй бол үгүй-2, мэдээлэлгүй бол-3 гэж дугуйлна. Эмчилгээ хийлгэж байсан, тийм-1 гэж сонгосон бол ямар эмчилгээ хийлгэснийг тоочиж бичнэ.
Асуулт 18: Жирэмсэлсэн хэлбэр	Эхийн жирэмсэлсэн хэлбэрийг тохирох кодоос сонгож дугуйлна.

Асуулт 19: Жирэмсний эхний 12 долоо хоногийн дотор фолийн хүчил уусан эсэх	Жирэмсний эхний 12 долоо хоног буюу жирэмсний эхний 3 сар дотор фолийн хүчил 0.4 мг-аар өдөр бүр тогтмол уусан бол-1, тогтмол уугаагүй бол-2, огт уугаагүй бол-3, фолийн хүчил уусан гэсэн мэдээлэл байхгүй бол мэдээлэлгүй-4 гэсэн кодыг сонгоно.
Е. Удамшил	
Асуулт 1: Хүүхдэд төрөлхийн хөгжлийн гажигтай ах, эгч, дүү байгаа эсэх	Энэ хүүхдэд төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн ах, эгч, дүү байгаа эсэхийг тохирох кодоос сонгоно. Ах, эгч, дүү нь тухайн хүүхэдтэй ижил төрөлхийн хөгжлийн гажигтай бол ижил гажиг-1, тухайн хүүхдээс өөр төрөлхийн хөгжлийн гажигтай бол өөр гажиг-2, тухайн хүүхэдтэй ижил эсвэл тухайн хүүхдээс өөр төрөлхийн хөгжлийн гажигтай ах, эгч, дүү байгаа бол ижил болон өөр гажиг-3, төрөлхийн хөгжлийн гажигтай ах, эгч, дүү байхгүй бол үгүй-4, төрөлхийн хөгжлийн гажигтай ах, эгч, дүү байгаа эсэх талаар мэдээлэлгүй бол тодорхойгүй-5 гэсэн кодоос дугуйлна.
Асуулт 2: Эхийн төрөл садан дотор төрөлхийн хөгжлийн гажигтай хүн байсан эсэх	Эхэд өөрт нь эсвэл эхийн талын төрөл саданд төрөлхийн хөгжлийн гажигтай хүн байгаа эсэхийг тохирох кодоос сонгоно.
Асуулт 3: Эцгийн төрөл садан дотор төрөлхийн хөгжлийн гажиг тодорхойлогдож байсан эсэх	Эцэгт нь эсвэл эцгийн талын төрөл саданд төрөлхийн хөгжлийн гажигтай хүн байгаа эсэхийг тохирох кодоос сонгоно.

“Амьгүй төрөлт, нярайн эндэгдлийг мэдээлэх хуудас” СТ-12 хөтлөх заавар

(амьгүй төрөлтийн үед)

Асуумж	Аргачлал-Тодорхойлолт – Жишээ
А. Ерөнхий мэдээлэл	
Мэдээлсэн огноо	Мэдээлсэн хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ. Жишээ: *2014* он *4* сарын *8* өдөр *13* цаг *30* минут гэж бичнэ.
Мэдээлсэн газар	Аймаг/хот *Орхон* Сум/дүүрэг *Жаргалант* Эмчийн овог, нэр *Б.Жаргалмаа* Албан тушаал *Эх барих эмэгтэйчүүдийн эмч*
Б. Хувь хүний тухай мэдээлэл	
Асуулт 1: Эхийн регистрийн дугаар	Регистрийн дугаарыг бөглөхдөө тухайн нярайн эхийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Регистрийн дугаар гэсэн 10 нүд бүхий

	хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр, сүүлийн 8 нүдэнд цифрийг тус бүрт гаргацтай бичнэ. *Жишээ* *А Н 8 6 0 2 2 4 6 5*
Асуулт 2: Эхийн овог нэр	Эхийн иргэний бүртгэлээс баталгаажсан иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн овог, нэрийг тод гаргацтай, татлахгүй, үнэн, зөв бичнэ. Жишээ: Эхийн овог Сүрэн нэр Саруул
Асуулт 3: Эхийн нас	Нас гэсэн 2 нүд бүхий хүснэгтэд эхийн төрсөн оныг үндэслэн насыг тооцоолж бүтэн насаар бичнэ. *Жишээ: 1985 онд төрсөн эх байвал 2014 оноос 1985 оныг хасаж 29* гэж тооцож бичнэ.
Асуулт 4: Оршин суугаа хаяг	Эхийн иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо зэргийг гаргацтай бичнэ. Жишээ: *Аймаг*/хот *Орхон* Сум/дүүрэг *Жаргалант* Баг/хороо *Улаантолгой баг*
Асуулт 5: Ам бүл	Ам бүлийн тоог эхийн жирэмсний хяналтын хөтөч, өвчний түүх, төрөлтийн түүхийн паспортын хэсгээс харж үнэн зөв бөглөнө. Жишээ: 3 ам бүлтэй бол Ам бүл: *3* гэж бичнэ.
Асуулт 6: Ажил эрхлэлт	Ажил эрхлэлтийг сонгохдоо тохирох хариултыг дугуйлна, дээрх хариултын алинд нь ч орохгүй бол бусад гэсэн хариултыг дугуйлж, тодорхой бичнэ үү.
Асуулт 7: Жирэмслэлтийн тоо	Жирэмслэлтийн тоог бөглөхдөө жирэмсний хяналтын хөтөчөөс харж, одоогийн жирэмслэлтийг оролцуулан нийт жирэмслэлтийн тоог бичнэ. Хэрэв нэг оронтой байвал аравтын оронд 0 гэж бичнэ. Жишээ: 0 3
Асуулт 8: Өмнөх төрөлтийн тоо	Өмнөх төрөлтийн тоонд одоогийн жирэмсний төгсгөлийг оруулахгүйгээр нийт төрөлтийн тоог бичнэ. Ихэр бол нэг төрөлтөнд тооцно. Жирэмсний хяналтын хөтөчөөс харж тэмдэглэх ба хэрэв нэг оронтой байвал аравтын оронд 0 гэж бичнэ. Жишээ: 0 3
Асуулт 9: Жирэмсний хяналтанд байсан эсэх	Жирэмсний *хяналтанд байсан бол тийм-1, байгаагүй бол үгүй-2* гэж тэмдэглэнэ. Жирэмсний хяналтад байсан эсэх тодорхойгүй байвал мэдээлэлгүй-3 гэж хариулна. Түүнчлэн, жирэмсний хяналтанд байгаагүй бол 12-р асуулт руу шилжинэ.
Асуулт 10: Жирэмсний хяналтанд орсон хугацаа	Жирэмсний хяналтанд анх орсон хугацааг долоо хоногоор тооцож тэмдэглэнэ. Тухайн эхийн жирэмсний хяналтанд орсон хугацааг 2 нүд бүхий хүснэгтийн эхний нүдэнд аравтын, сүүлийн нүдэнд нэгжийн орон байхаар нөхнө. Хэрэв нэг оронтой байвал аравтын оронд 0 гэж бичнэ. *Жишээ: 7 долоо хоногтой хяналтанд орсон бол 0 7* гэж тэмдэглэнэ.
Асуулт 11: Жирэмсний хяналтын эмчийн мэргэжлийн түвшин	Жирэмсний хяналтын эмчийн мэргэжлийн түвшинг кодын дагуу сонгоно.

Асуулт 12: Жирэмсэн үеийн хүндрэл	Одоогийн жирэмсний явцад тохиолдсон хүндрэлийг тохирох хариултын кодоос сонгоно. Нэгээс олон хариулт сонгож болно. Эхэд тохиолдсон жирэмсний хүндрэл дээрх хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, хүндрэлийг тодорхой бичнэ. Хүндрэлгүй тохиолдолд хүндрэлгүй гэсэн хариултыг сонгоно.
Асуулт 13: Эхийн эмгэг	Эхэд жирэмсэнтэй хавсарсан эрхтэн тогтолцооны эмгэг байвал тохирох хариултын кодыг сонгоно. Нэгээс олон хариулт сонгож болно. Эхэд тохиолдсон эрхтэн тогтолцооны эмгэг дээрх хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, эмгэгийн нэрийг тодорхой бичнэ. Мөн халдварт ба шимэгчит зарим өвчин гэсэн хариултыг сонгосон бол тодорхой бичнэ.
Асуулт 14: Антенаталь үеийн эмийн хэрэглээ	Жирэмсэн үед хэрэглэсэн эмийн хэрэглээг бичих бөгөөд дутуу төрөлтийн үед дексаметазон хэрэглэсэн эсэхийг тодруулж бичнэ. Бусад гэсэн хариуг сонгосон бол эмийн нэрийг дэлгэрэнгүй, тоочиж бичнэ. Жишээ: 1. *Дексаметазон*
Асуулт 15: Төрсөн газар	Нярайн төрсөн газрыг өгөгдсөн кодоос сонгож тэмдэглэнэ. Хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, төрсөн газрын нэрийг тодорхой бичнэ. *Жишээ: 2. Хотын амаржих газрууд*
Асуулт 16: Төрөлтийн хэлбэр	Төрөлтийн хэлбэрийг төрөх замаар-1, хагалгаагаар-2 гэсэн хариултын аль нэгийг сонгоно. Төрөх замаар төрсөн бол доорх аргуудаас сонгоно, олон хариулттай байж болно. Төрөх замаар төрсөн тохиолдолд 18-р асуулт руу шилжинэ. *Жишээ: 2. Хагалгаа*
Асуулт 17: Хагалгаа хийсэн заалт	Нярай кесар хагалгаагаар төрсөн бол хагалгаа хийгдсэн заалтаас тохирох кодыг сонгоно, олон хариулттай байж болно. Бусад гэсэн хариуг сонгосон бол хагалгаа хийгдсэн заалтыг дэлгэрэнгүй бичнэ. *Жишээ: 2. Манас таталт*
Асуулт 18: Түрүүлсэн хэсэг	Ургийн түрүүлсэн хэсгийг тохирох кодоос сонгоно. Бусад гэсэн кодыг сонгосон тохиолдолд хариултыг тодорхой бичнэ. *Жишээ: 1. Толгой*
Асуулт 19: Төрөлтийн үеийн хүндрэл	Төрөлтийн үеийн хүндрэл тохиолдвол тохирох кодыг сонгоно. Бусад гэсэн кодыг сонгосон тохиолдолд хүндрэлийг тодорхой бичнэ. *Жишээ: 1. Төрөлтийн саатал*
Асуулт 20: Ургийн хүндрэл	Урагт хүндрэл тохиолдвол тохирох кодыг сонгоно. Бусад гэсэн кодыг сонгосон тохиолдолд хүндрэлийг тодорхой бичнэ. *Жишээ: 3. Өсөлт хөгжлийн саатал*
	B. Нярайн талаарх мэдээлэл
Асуулт 1: Нярайн төрсөн он, сар, өдөр	Нярайн төрсөн он, сар, өдрийг тодорхой бичнэ. *Жишээ: Нярай 2014 оны 3 сарын 16 өдөр* гэж тэмдэглэнэ.

Асуулт 2: Энэ төрөлтөөр төрүүлсэн хүүхдийн тоо (амьд, амьгүй хүүхдийн тоо)	Эх энэ удаагийн төрөлтөөр хэдэн хүүхэд (амьд, амьгүй) төрүүлсэн тоог өгөгдсөн нүдэнд тэмдэглэнэ.
Асуулт 3: Энэ нярай ихэр хүүхдийн хэд дэх хүүхэд вэ?	Эхийн энэ удаагийн ихэр төрөлтийн хэд дэх хүүхдийг тодруулах зорилго бүхий асуултанд хариулахдаа тухайн амьгүй нярай нь ихэр төрсөн бол нярайн төрөх үеийн дараалын дагуу бичнэ. *Жишээ: Эх 2 ихэр хүүхэд төрүүлэхэд эхний хүүхэд амьгүй төрсөн бол 1 дэх* гэж бичнэ.
Асуулт 4: Нас баралтын ангилал	Нас баралтын ангиллыг доорх кодоос сонгож дугуйлна.
Асуулт 5: Хүйс	Нярайн хүйсийг *эр-1, эм-2* гэж тэмдэглэнэ.
Асуулт 6-7: Нярайн жин, өндөр	Нярайг үзсэн эмчийн анхны үзлэгийн биеийн жин, өндрийн хэмжээг бичиж тэмдэглэнэ.
Асуулт 8: Төрөх үеийн тээлтийн нас	Нярайн төрөх үеийн тээлтийн насыг долоо хоног, хоногоор бичнэ.
Жич: Та амьгүй төрөлтийг мэдээлж байгаа тохиолдолд 18-р асуулт руу шилжинэ.	
Асуулт 18: Эмнэлзүйн онош (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош)	Эмнэлзүйн үндсэн оношийг (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош) гаргацтай бичих ба ӨОУА-10 гэдгийн ард оношийн кодыг бичиж өгнө.
Та амьгүй төрөлт мэдээлж байгаа тул 23-р асуултад шууд шилжинэ.	
Асуулт 23: Эмгэг судлалын шинжилгээнд орсон эсэх	Эмгэг судлалын шинжилгээнд *орсон бол тийм-1, ороогүй бол үгүй-2* гэж дугуйлна.
Асуулт 24: Эмгэг судлалын онош (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош)	Эмгэг судлалын шинжилгээнд орсон бол эмгэг судлалын шинжилгээний оношийг (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош) дэлгэрэнгүй бичиж оруулахаас гадна ӨОУА-10-аар кодлоно.
Асуулт 25-26: Онош тохирсон эсэх	Эмгэг судлалын шинжилгээний онош эмнэлзүйн оноштой тохирсон эсэхийг өгөгдсөн кодыг ашиглан хариулах ба онош тохироогүй бол кодыг ашиглан дугуйлна.

(нярайн эндэгдлийн үед)

Асуумж	Аргачлал-Тодорхойлолт – Жишээ
А. Ерөнхий мэдээлэл	
Мэдээлсэн огноо	Мэдээлсэн хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ. *Жишээ: 2014 оны 04 сарын 08 өдөр 13 цаг 30 минут* гэж бичнэ.
Мэдээлсэн газар	Аймаг/хот *Архангай* Сум/дүүрэг *Тариат* Эмчийн овог, нэр *Д. Солонго* Албан тушаал *Хүүхдийн эмч*
Б. Хувь хүний тухай мэдээлэл	
	Регистрийн дугаарыг бөглөхдөө тухайн нярайн эхийн иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээнд бичсэн регистрийн дугаарыг үндэслэн бичнэ. Регистрийн дугаар гэсэн 10 нүд бүхий хүснэгтийн эхний 2 нүдэнд үсгийг том үсгээр,

Асуулт 1: Эхийн регистрийн дугаар	сүүлийн 8 нүдэнд цифрийг тус бүрт гаргацтай бичнэ. *Жишээ* *А Н 8 6 0 2 2 4 6 5*
Асуулт 2: Эхийн овог, нэр	Эхийн иргэний бүртгэлээс баталгаажсан иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээг үндэслэн овог, нэрийг тод гаргацтай, татлахгүй, үнэн, зөв бичнэ. *Жишээ: Эхийн овог Сүрэн нэр Саруул*
Асуулт 3: Эхийн нас	Нас гэсэн 2 нүд бүхий хүснэгтэд эхийн төрсөн оныг үндэслэн насыг тооцоолж бүтэн насаар бичнэ. *Жишээ: 1985 онд төрсөн эх байвал 2014 оноос 1985 оныг хасаж 29 гэж тооцож бичнэ.*
Асуулт 4: Оршин суугаа хаяг	Эхийн иргэний үнэмлэхийг үндэслэн аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо зэргийг гаргацтай бичнэ. Жишээ: Аймаг/хот *Орхон* Сум/дүүрэг *Жаргалант* Баг/хороо *Улаантолгой баг*
Асуулт 5: Ам бүл	Ам бүлийн тоог эхийн жирэмсний хяналтын хөтөч, өвчний түүх, төрөлтийн түүхийн паспортын хэсгээс харж үнэн зөв бөглөнө.
Асуулт 6: Ажил эрхлэлт	Ажил эрхлэлтийг сонгохдоо тохирох хариултыг дугуйлна, дээрх хариултын алинд нь ч орохгүй бол бусад гэсэн хариултыг дугуйлж, тодорхой бичнэ үү.
Асуулт 7: Жирэмслэлтийн тоо	Жирэмслэлтийн тоог жирэмсний хяналтын хөтчөөс харж, одоогийн жирэмслэлтийг оролцуулан нийт жирэмслэлтийн тоог бичнэ. Хэрэв нэг оронтой байвал аравтын оронд 0 гэж бичнэ. *Жишээ: 0 3*
Асуулт 8: Өмнөх төрөлтийн тоо	Өмнөх төрөлтийн тоонд одоогийн жирэмсний төгсгөлийг оруулахгүйгээр нийт төрөлтийн тоог бичнэ. Ихэр бол нэг төрөлтөнд тооцно. Жирэмсний хяналтын хөтчөөс харж тэмдэглэх ба хэрэв нэг оронтой байвал аравтын оронд 0 гэж бичнэ. *Жишээ: 0 3*
Асуулт 9: Жирэмсний хяналтанд байсан эсэх	Жирэмсний *хяналтанд байсан бол тийм-1, байгаагүй бол үгүй-2* гэж тэмдэглэнэ. Жирэмсний хяналтанд байсан эсэх нь тодорхойгүй байвал мэдээлэлгүй-3 гэж хариулна. Түүнчлэн, жирэмсний хяналтанд байгаагүй бол 12-р асуулт руу шилжинэ.
Асуулт 10: Жирэмсний хяналтанд орсон хугацаа	Жирэмсний хяналтанд анх орсон хугацааг долоо хоногоор тооцож тэмдэглэнэ. Тухайн эхийн жирэмсний хяналтанд орсон хугацааг 2 нүд бүхий хүснэгтийн эхний нүдэнд аравтын, сүүлийн нүдэнд нэгжийн орон байхаар нөхнө. Хэрэв нэг оронтой байвал аравтын оронд 0 гэж бичнэ. *Жишээ: 7 долоо хоногтой хяналтанд орсон бол 0 7 гэж тэмдэглэнэ.*

Асуулт 11: Жирэмсний хяналтын эмчийн мэргэжлийн түвшин	Жирэмсний хяналтын эмчийн мэргэжлийн түвшинг кодын дагуу сонгоно.
Асуулт 12: Жирэмсэн үеийн хүндрэл	Одоогийн жирэмсний явцад тохиолдсон хүндрэлийг тохирох хариултын кодоос сонгоно. Нэгээс олон хариулт сонгож болно. Эхэд тохиолдсон жирэмсний хүндрэл дээрх хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, хүндрэлийг тодорхой бичнэ. Хүндрэлгүй тохиолдолд хүндрэлгүй гэсэн хариултыг сонгоно.
Асуулт 13: Эхийн эмгэг	Эхэд жирэмсэнтэй хавсарсан эрхтэн тогтолцооны эмгэг байвал тохирох хариултын кодыг сонгоно. Нэгээс олон хариулт сонгож болно. Эхэд тохиолдсон эрхтэн тогтолцооны эмгэг дээрх хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, эмгэгийн нэрийг тодорхой бичнэ. Халдварт ба шимэгчит зарим өвчин гэсэн хариултыг сонгосон бол тодорхой бичнэ.
Асуулт 14: Антенаталь үеийн эмийн хэрэглээ	Жирэмсэн үед хэрэглэсэн эмийн хэрэглээг бичих бөгөөд дутуу төрөлтийн үед дексаметазон хэрэглэсэн эсэхийг тодруулж бичнэ. Бусад гэсэн хариуг сонгосон бол эмийн нэрийг дэлгэрэнгүй, тоочиж бичнэ. *Жишээ: 1. Дексаметазон*
Асуулт 15: Төрсөн газар	*Нярайн төрсөн газрыг өгөгдсөн кодоос сонгож тэмдэглэнэ. Хариултад тохирохгүй байвал бусад гэсэн хариултыг сонгоод, төрсөн газрын нэрийг тодорхой бичнэ. Жишээ: 2. Хотын амаржих газрууд*
Асуулт 16: Төрөлтийн хэлбэр	Төрөлтийн хэлбэрийг төрөх замаар-1, хагалгаагаар-2 гэсэн хариултын аль нэгийг сонгоно. Төрөх замаар төрсөн бол доорх аргуудаас сонгоно, олон хариулттай байж болно. Төрөх замаар төрсөн тохиолдолд 18-р асуулт руу шилжинэ. *Жишээ: 2. Хагалгаа*
Асуулт 17: Хагалгаа хийсэн заалт	Нярай кесар хагалгаагаар төрсөн бол хагалгаа хийгдсэн заалтаас тохирох кодыг сонгоно, олон хариулттай байж болно. Бусад гэсэн хариуг сонгосон бол хагалгаа хийгдсэн заалтыг дэлгэрэнгүй бичнэ. *Жишээ: 2. Манас таталт*
Асуулт 18: Түрүүлсэн хэсэг	Ургийн түрүүлсэн хэсгийг тохирох кодоос сонгоно. Бусад гэсэн кодыг сонгосон тохиолдолд хариултыг тодорхой бичнэ. *Жишээ: 1. Толгой*
Асуулт 19: Төрөлтийн үеийн хүндрэл	Төрөлтийн үеийн хүндрэл тохиолдвол тохирох кодыг сонгоно. Бусад гэсэн кодыг сонгосон тохиолдолд хүндрэлийг тодорхой бичнэ. *Жишээ: 1. Төрөлтийн саатал*

Асуулт 20: Ургийн хүндрэл	Урагт хүндрэл тохиолдвол тохирох кодыг сонгоно. Бусад гэсэн кодыг сонгосон тохиолдолд хүндрэлийг тодорхой бичнэ. *Жишээ: 3. Өсөлт хөгжлийн саатал*
В. Нярайн талаарх мэдээлэл	
Асуулт 1: Нярайн төрсөн он, сар, өдөр	Нярайн төрсөн он, сар, өдрийг тодорхой бичнэ. *Жишээ: Нярай 2014 оны 3 сарын 16 өдөр* гэж тэмдэглэнэ
Асуулт 2: Энэ төрөлтөөр төрүүлсэн хүүхдийн тоо (амьд, амьгүй хүүхдийн тоо)	Эх энэ удаагийн төрөлтөөр хэдэн хүүхэд (амьд, амьгүй) төрүүлсэн тоог өгөгдсөн нүдэнд тэмдэглэнэ.
Асуулт 3: Энэ нярай ихэр хүүхдийн хэд дэх хүүхэд вэ?	Эхийн энэ удаагийн ихэр төрөлтийн хэд дэх хүүхдийг тодруулах зорилго бүхий асуултанд хариулахдаа эндсэн нярай нь ихэр төрсөн бол *нярайн төрөх үеийн дараалын дагуу бичнэ. Жишээ: Эх 2 ихэр хүүхэд төрүүлэхэд эхний хүүхэд амьгүй төрсөн бол 1 дэх* гэж бичнэ.
Асуулт 4: Нас баралтын ангилал	Нас баралтын ангиллыг доорх кодоос сонгож дугуйлна.
Асуулт 5: Хүйс	Нярайн хүйсийг *эр-1, эм-2* гэж тэмдэглэнэ.
Асуулт 6-7: Биеийн жин, өндөр	Нярайг үзсэн эмчийн анхны үзлэгийн биеийн жин, өндрийн хэмжээг бичиж тэмдэглэнэ.
Асуулт 8: Төрөх үеийн тээлтийн нас	Нярайн төрөх үеийн тээлтийн насыг долоо хоног, хоногоор бичнэ.
Асуулт 9: Апгарын үнэлгээ	Амьд төрсөн нярайд Апгарын оноог төрсний дараах 1 минут, 5 минутын байдлаар тэмдэглэнэ.
Асуулт 10: Нярайд нэн шаардлагатай тусламж хэрэгжүүлсэн эсэх	Нярайн нэн шаардлагатай тусламж үзүүлсэн бол асуултад өгөгдсөн кодыг ашиглан хариулна, олон хариулттай байж болно. Нэн шаардлагатай тусламж үзүүлсэн талаар мэдээлэл байхгүй бол мэдээлэлгүй гэж бөглөнө. *Жишээ: 3. Мэдээлэлгүй*
Асуулт 11: Сэхээн амьдруулалт хийгдсэн эсэх	Нярайд сэхээн амьдруулалт хийгдсэн эсэхийг хариулахдаа асуумжид байгаа хариултаас сонгох ба олон хариулт дугуйлж болно. Сэхээн амьдруулалт хийгдсэн талаар мэдээлэл байхгүй бол мэдээлэлгүй гэж бөглөнө.
Асуулт 12: Сэхээн амьдруулалтыг үзүүлсэн хүн	Нярайд сэхээн амьдруулалт үзүүлсэн хүний мэргэжлийг кодоос сонгоно. Жагсаалтад байхгүй хариулт гарвал бусад гэсэн кодыг сонгож, хариултыг дэлгэрэнгүй бичнэ.
Асуулт 13: Нярайн өвчний улмаас эмнэлэгт хэвтсэн	Нярайн эмнэлэгт хэвтсэн хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ. Үүнийг нярайн өвчний түүхээс авч тэмдэглэнэ. *Жишээ: 2014 он 1 сар 5 өдөр 14 цаг 15 минут гэж бичнэ.*
Асуулт 14: Хэвтэх үеийн нярайн нас	Нярайн эмнэлэгт хэвтэх үеийн насыг өвчний түүхээс харж хоног, цаг, минутаар бичнэ.
Асуулт 15: Эмнэлэгт байх үед эмчилгээ хийгдсэн эсэх	Нярайд эмнэлэгт байх үед ямар нэгэн эмчилгээ хийгдсэн бол асуултад өгөгдсөн кодыг ашиглан хариулна. Олон хариулт байж болно.
Асуулт 16: Гипогликеми илэрсэн эсэх	Нярайн шинжилгээнд гипогликеми *илэрсэн бол тийм-1, илрээгүй бол үгүй-2, мэдээлэлгүй бол-3* гэж кодлоно. Үгүй гэж хариулсан бол 18-р асуулт руу шилжинэ.

Асуулт 17: Гипогликемийн эмчилгээ хийсэн эсэх	Гипогликемийн эмчилгээ хийсэн бол *тийм-1, хийгээгүй бол үгүй-2, мэдээлэлгүй бол-3* гэж дугуйлна.
Асуулт 18: Эмнэлзүйн онош (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош)	Эмнэлзүйн үндсэн оношийг (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош) гаргацтай бичиж ӨОУА-10 гэдгийн ард оношийн кодыг бичнэ.
Асуулт 19: Нярайн эндсэн газар	Нярайн эндсэн газрыг өгөгдсөн хариултын кодоос сонгоно. Бусад гэсэн кодыг сонгосон тохиолдолд эндсэн газрыг тодорхой бичнэ.
Асуулт 20: Нас барах үеийн нярайн нас	Нас барах үеийн нярайн нас, ор хоногийг хоног, цаг, минутаар бичнэ.
Асуулт 21: Ор хоног	Нярайн нас барах хүртэл эмнэлэгт хэр удаан байсан хугацааг буюу ор хоногийг хоног, цаг, минутаар нь бичнэ. Эхний 2 нүдэнд хоногийг, дунд 2 нүдэнд цагийг, сүүлийн 2 нүдэнд минутыг бичнэ. *Жишээ: Ор хоног 2 хоног 6 цаг 25 минут* бол *0 2* ☐☐ *хоног* ☐*0*☐*6* ☐ *цаг 2* ☐*5*☐ *минут* гэж тэмдэглэнэ.
Асуулт 22: Нярайн нас барсан хугацаа	Нярайн нас барсан хугацааг он, сар, өдөр, цаг, минутаар бичнэ. *Жишээ: Нярай нас барсан: 2014 он 2 сар 13 өдөр 16 цаг 20 минут* гэж тэмдэглэнэ.
Асуулт 23: Эмгэг судлалын шинжилгээнд орсон эсэх	Эмгэг судлалын шинжилгээнд *орсон бол тийм-1, ороогүй бол үгүй-2* гэж дугуйлна
Асуулт 24: Эмгэг судлалын шинжилгээний онош (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош)	Эмгэг судлалын шинжилгээнд орсон бол эмгэг судлалын шинжилгээний оношийг (үндсэн онош, хүндрэл, дагалдах онош) дэлгэрэнгүй бичиж, ӨОУА-10-аар кодлоно.
Асуулт 25-26: Онош тохирсон эсэх	Эмгэг судлалын шинжилгээний онош эмнэлзүйн оноштой тохирсон эсэхийг өгөгдсөн кодыг ашиглан хариулах ба онош тохироогүй бол кодыг ашиглан дугуйлна.

КОДЛОХ ЗААВАР

САЛБАРЫН АНГИЛАЛ, ДЭД САЛБАР

№	Код	Салбарын нэр
A		**Хөдөө аж ахуйн, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур**
	01	Газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, ан агнуур болон түүнд холбогдох туслах үйл ажиллагаа
	02	Ойн аж ахуй, мод бэлтгэл
	03	Загас барих, үржүүлэх
B		**Уул уурхай, олборлолт**
	05	Чулуун, хүрэн нүүрс олборлолт
	06	Газрын тос, байгалийн хий олборлолт
	07	Металлын хүдэр олборлолт
	08	Бусад ашигт малтмал олборлолт
	09	Уул уурхайн олборлолтын туслах үйл ажиллагаа
C		**Боловсруулах үйлдвэрлэл**
	10	Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	11	Ундааны үйлдвэрлэл
	12	Тамхины үйлдвэрлэл
	13	Нэхмэлийн үйлдвэрлэл
	14	Хувцас үйлдвэрлэл
	15	Арьс, арьсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл
	16	Тавилгаас бусад мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл; сүрэл, дэрсэн эдлэл үйлдвэрлэл
	17	Цаас болон цаасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	18	Хэвлэх, дуу бичлэгийн хувилах, дахин үйлдвэрлэх үйл ажиллагаа
	19	Кокс болон газрын тосны боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	20	Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	21	Эм, эм бэлдмэл, химийн болон ургамлын гаралтай эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	22	Резинэн болон хуванцар бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	23	Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл
	24	Металл үйлдвэрлэл

	25	Машин, тоног төхөөрөмжөөс бусад металл бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	26	Компьютер, электроник болон хараа зүйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл
	27	Цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл
	28	Дээрх дэд салбарт ороогүй бусад машин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл
	29	Моторт авто тээврийн хэрэгсэл, чиргүүл, хагас чиргүүл үйлдвэрлэл
	30	Тээврийн хэрэгслийн бусад тоног төхөөрөмж үйлдвэрлэл
	31	Тавилга үйлдвэрлэл
	32	Бусад боловсруулах үйлдвэрлэл
	33	Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар, үйлчилгээ
D		**Цахилгаан хий, уур, агааржуулалт**
	35	Цахилгаан хий, уур, агааржуулалт
E		**Ус хангамж, бохир ус, хог,хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа**
	36	Ус цуглуулах, ариутгах, ус хангамж
	37	Бохир ус цуглуулах, цэвэршүүлэх, ариутгах үйл ажиллагаа
	38	Хог хаягдлыг цуглуулах, ариутгах, боловсруулах үйл ажиллагаа
	39	Хог, хаягдлын менежментийн бусад болон цэвэрлэх үйл ажиллагаа
F		**Барилга**
	41	Барилга угсралт
	42	Иргэний зориулалттай инженерийн байгууламжийн угсралтын үйл ажиллагаа
	43	Барилгын тусгай үйл ажиллагаа
G		**Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ**
	45	Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ
	46	Машин, мотоциклээс бусад барааны бөөний худалдаа
	47	Машин, мотоциклээс бусад барааны жижиглэн худалдаа
H		**Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа**
	49	Хуурай замын болон хий дамжуулах хоолойн тээвэрлэлт
	50	Усан замын тээвэр
	51	Агаарын тээвэр

	52	Агуулахын болон тээврийн туслах үйл ажиллагаа
	53	Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа
I		**Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа**
	55	Зочид буудал, байр, сууцаар үйлчлэх үйл ажиллагаа
	56	Нийтийн хоолны үйлчилгээ
J		**Мэдээлэл, холбоо**
	58	Эх бэлтгэх, нийтлэх үйл ажиллагаа
	59	Кино, видео, телевизийн хөтөлбөрийн үйлдвэрлэл, бичлэг хийх болон хөгжим, ая үйлдвэрлэх үйл ажиллагаа
	60	Өргөн нэвтрүүлэг бэлтгэх, дамжуулах үйл ажиллагаа
	61	Цахилгаан холбоо
	62	Компьютер програмчлал, зөвлөгөө болон түүнд холбогдох үйл ажиллагаа
	63	Мэдээллээр үйлчлэх үйл ажиллагаа
K		**Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа**
	64	Даатгалын болон тэтгэврийн санхүүжилтийн үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээний үйл ажиллагаа
	65	Албан журмын нийгмийн даатгалаас бусад даатгал, давхар даатгал, тэтгэврийн санхүүжилтын үйл ажиллагаа
	66	Санхүүгийн бусад үйл ажиллагаа
L		**Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа**
	68	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа
M		**Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа**
	69	Хуулийн болон бүртгэлийн үйл ажиллагаа
	70	Аж ахуйн нэгжийн удирдах дээд байгууллагын үйл ажиллагаа; менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа
	71	Архитектур болон инженерийн үйл ажиллагаа; техникийн туршилт, шинжилгээ
	72	Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, ололт, судалгааны үйл ажиллагаа
	73	Сурталчилгааны ажил, зах зээлийн судалгаа
	74	Мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн ажлын бусад үйл ажиллагаа
	75	Мал эмнэлгийн үйл ажиллагаа
N		**Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа**

	77	Түрээс, лизингийн үйл ажиллагаа
	78	Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаа
	79	Аялал, жуулчлалын агентлаг, аяллын оператор болон захиалгат бусад үйлчилгээний үйл ажиллагаа
	80	Аюулгүйн хамгаалал, мөрдөх үйл ажиллагаа
	81	Байшин, барилга болон цэцэрлэг, газрын гадаргыг арчлах, хамгаалах үйл ажиллагаа
	82	Албан байгууллагын удирдлагын болон туслах үйл ажиллагаа, бизнесийн бусад туслах үйл ажиллагаа
O		**Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал**
	84	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал
P		**Боловсрол**
	85	Боловсрол
Q		**Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа**
	86	Хүний эрүүл мэндийн үйл ажиллагаа
	87	Оршин суугчдад үзүүлэх нийгмийн халамжийн үйл ажиллагаа
	88	Зориулалтын байргүйгээр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх нийгмийн тусламжийн үйл ажиллагаа
R		**Урлаг, үзвэр, тоглоом наадам**
	90	Бүтээл туурвих, урлаг, үзвэр үйлчилгээний үйл ажиллагаа
	91	Номын сан, архив, музей болон бусад соёлын үйл ажиллагаа
	92	Мөрийтэй тоглоомын газрын үйл ажиллагаа
	93	Спорт, зугаа цэнгэл, чөлөөт цагийн үйл ажиллагаа
S		**Үйлчилгээний бусад үйл ажиллагаа**
	94	Гишүүнчлэл бүхий байгууллагын үйл ажиллагаа
	95	Хувийн болон өрхийн хэрэглээний зориулалттай бараа, компьютерын засвар, үйлчилгээ
	96	Хувийн үйлчилгээний бусад үйл ажиллагаа
T		**Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа**
	97	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа

	98	Өрхийн өөрийн хэрэглээнд зориулсан, нэр төрлөөр нь салгаж тодорхойлох боломжгүй бараа, үйлчилгээний үйлдвэрлэлт
U		**Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа**
	99	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа

АЖИЛ, МЭРГЭЖЛИЙН ҮНДСЭН БА ДЭД АНГИЛАЛ

№	Код	Мэргэжлийн ангилал
1		**Менежер**
	11	Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан, гүйцэтгэх захирал
	12	Захиргаа, арилжааны менежер
	13	Үйлдвэрлэл, төрөлжсөн үйлчилгээний менежер
	14	Зочид буудал, худалдаа, холбогдох бусад үйлчилгээний менежер
2		**Мэргэжилтэн**
	21	Шинжлэх ухаан, инженерийн мэргэжилтэн
	22	Эрүүл мэндийн мэргэжилтэн
	23	Багшлах мэргэжилтэн
	24	Бизнес, захиргааны мэргэжилтэн
	25	Мэдээлэл, холбооны технологийн мэргэжилтэн
	26	Хууль, нийгэм, соёлын мэргэжилтэн
3		**Техникч болон туслах/дэд мэргэжилтэн**
	31	Шинжлэх ухаан, инженерийн туслах/дэд мэргэжилтэн
	32	Эрүүл мэндийн туслах/дэд мэргэжилтэн
	33	Бизнесийн болон захиргааны туслах/дэд мэргэжилтэн
	34	Хууль, нийгэм, соёл, тэдгээрт холбогдох бусад туслах/дэд мэргэжилтэн
	35	Мэдээлэл, холбооны техникч
4		**Контор, үйлчилгээний ажилтан**
	41	Конторын үндсэн болон гүйцэтгэх ажилтан
	42	Хэрэглэгчдэд үйлчлэх ажилтан
	43	Тооцоолол, материал бүртгэлийн ажилтан
	44	Конторын бусад туслах ажилтан
5		**Худалдаа, үйлчилгээний ажилтан**
	51	Худалдаа, үйлчилгээний ажилтан
	52	Борлуулалтын ажилтан
	53	Хувь хүн асрамжлах үйлчилгээ
	54	Хамгаалах үйлчилгээний ажилтан
6		**Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан**
	61	Зах зээлд чиглэсэн хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан
	62	Зах зээлд чиглэсэн ой, загасны аж ахуй, ан агнуур эрхлэгч
	63	Өрхийн хэрэгцээт амь зуулгын фермч, загасчин, анчин, түүгч, хураагч
7		**Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан**
	71	Барилга, түүнтэй холбогдох ажил, мэргэжлийн ажилтан (цахилгаанчаас бусад)
	72	Металл, машин механизм, холбогдох ажил, мэргэжлийн ажилтан
	73	Гар урлал, хэвлэлийн ажилтан

	74	Цахилгаан, цахим техникч
	75	Хүнс үйлдвэрлэгч, мод боловсруулагч, хувцас бусад хийцийн зүйл хийгч,
8		**Суурин төхөөрөмж, машин мехнизмын операторч, угсрагч**
	81	Машин механизм, төхөөргийн операторч, угсрагч
	82	Угсрагч
	83	Жолооч, хөдөлгөөнт төхөөргийн операторч
9		**Энгийн ажил, мэргэжил**
	91	Цэвэрлэгч, туслагч
	92	Хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуйн ажил
	93	Уурхай, барилга угсралт, үйлдвэр, тээвэр, агуулахын ажил
	94	Хүнс бэлтгэлийн туслах ажил
	95	Гудамжин дахь худалдаа, үйлчилгээний ажил
	93	Бусад энгийн ажил
10		**Зэвсэгт хүчний ажил, мэргэжил**
	101	Зэвсэгт хүчний зэрэг, цол бүхий офицер
	102	Зэвсэгт хүчний ахлагч
	103	Зэвсэгт хүчний зэрэглэлийн бусад ажил, мэргэжил

БОЛОВСРОЛ

№	Код	Боловсролын ангилал
1	01	Боловсролгүй
2	02	Бага
3	03	Суурь боловсрол
4	04	Бүрэн дунд
5	05	Мэргэжлийн болон техникийн
6	06	Дипломын
7	07	Бакалавр
8	08	Магистр
9	08	Доктор

ХҮЙС

№	Код	Хүйс
1	01	Эрэгтэй
2	02	Эмэгтэй

ХАРЬЯАЛАЛ

№	Код	Аль улсын харьяат

1	01	Монгол улсын
2	02	Харьяалалгүй
3	03	Гадаадын /улсын нэр бичих/

СУУРЬШИЛ

№	Код	Суурьшлын байдал
1	01	Байнга оршин суудаг
2	02	Түр эзгүй
3	03	Түр суугаа

ОРОН СУУЦНЫ БАЙДАЛ

№	Код	Орон сууцны байдал
1	01	Гэр, сууц
2	02	Орон сууцны байшин
3	03	Бие даасан тохилог сууц
4	04	Сууцны тусдаа байшин
5	05	Оюутан сурагчдын нийтийн байр
6	06	Ажиллагчдын нийтийн байр
7	07	Нийтийн зориулалтын бусад байр
8	08	Зориулалтын бус сууц
9	09	Бусад

ӨРХИЙН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХАМААРАЛ

№	Код	Өрхийн тэргүүлэгчтэй ямар хамааралтай
1	01	Эхнэр/нөхөр
2	02	Хүү/охин
3	03	Эцэг/эх
4	04	Ах/эгч/дүү
5	05	Хадам эцэг/эх
6	06	Хүргэн/бэр
7	07	Өвөг эцэг/эмэг эх
8	08	Ач/зээ
9	09	Бусад төрөл төрөгсөд
10	10	Хамааралгүй

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ

№	Код	Хөгжлийн бэрхшээлийн төрөл
1	01	Төрөлхийн
2	02	Олдмол

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ХЭЛБЭР

№	Код	Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр
1	01	Харааны
2	02	Сонсголын
3	03	Хэл ярианы
4	04	Хөдөлгөөний
5	05	Сэтгэцийн

ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

№	Код	Гэрлэлтийн байдал
1	01	Огт гэрлээгүй
2	02	Батлуулсан гэр бүлтэй
3	03	Батлуулаагүй нэр бүлтэй
4	04	Тусгаарласан
5	05	Цуцалсан
6	06	Бэлбэсэн

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

№	Код	Хөдөлмөр эрхлэлтийн байдал
1	01	Цалин хөлстэй ажиллагч
2	02	Ажил олгогч
3	03	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
4	04	Нөхөрлөл хоршооны гишүүн
5	05	Мал аж ахуй эрхлэгч
6	06	Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч гишүүн
7	07	Бусад /бичнэ/

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХГҮЙ ШАЛТГААН

№	Код	Хөдөлмөр эрхлэхгүй шалтгаан
1	01	Сургуульд сурдаг
2	02	Тэтгэвэрт
3	03	Хөдөлмөр эрхлэх чадваргүй
4	04	Гэрийн ажилтай
5	05	Тохирох ажил олдохгүй
6	06	Ажил хайж байгаа
7	07	Ажиллах сонирхолгүй
8	08	Бусад /бичнэ/

№	Код	Тасгийн нэр
1	01	Дотрын
2	02	Мэс заслын
3	03	Төрөхийн
4	04	Эмэгтэйчүүдийн
5	05	Хүүхдийн
6	06	Халдвартын
7	07	Арьс харшлын
8	08	Сүрьеэгийн
9	09	Мэдрэлийн
10	10	Сэтгэцийн

11	11	Гэмтлийн
12	12	Нефрологийн
13	13	Урологийн
14	14	Эрчимт эмчилгээний
15	15	Нүдний
16	16	Чих хамар хоолой
17	17	Эрүү нүүрний
18	18	Хавдарын
19	19	Уламжлалт эмчилгээний
20	20	ДОХ, БЗДХ-ын
21	21	Хөнгөвчлөх эмчилгээний
22	22	Өдрийн эмчилгээ
23	23	Геронтологи
24	24	Нөхөн сэргээх эмчилгээний
25	25	Оношлогооны
26	26	Бусад

Боловсролын ангиллыг кодлох заавар

Сургуулийн өмнөх боловсрол
Бага насны хүүхдийн хөгжилд хэл ярианы баялагтай болох, хэлний мэдлэгээр өөрийгөө илэрхийлэх, бусадтай харилцаа үүсгэх, идэвхтэй тоглох бололцоогоор хангах, хүүхдийн хэл яриа, хөдөлгөөний чадварыг дэмжихүйц хөтөлбөрийг хамруулна. Зөвхөн хүүхэд асрах (хараа хяналт тавих, сувилах ба эрүүл мэндийн сувилгаа асаргаа) үйлчилгээ үзүүлдэг хөтөлбөрийг энд оруулахгүй.

Бага боловсрол
1975 он хүртэл ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангийг, 1975-1996 он хүртэлх ерөнхий боловсролын сургуулийн 3 дугаар ангийг, 1997-2004 он хүртэл ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангийг, 2005 оноос хойш ерөнхий боловсролын сургуулийн 5 дугаар ангийг төгсөгч болон бага боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр /албан бус боловсролын/-өөр бага боловсрол эзэмшсэн иргэнийг бага боловсролтой гэж үзэж энэ төвшинд хамруулна.
Суурь боловсрол
1975 он хүртэл ерөнхий боловсролын сургуулийн 7 дугаар ангийг, 1975-2004 он хүртэл ерөнхий боловсролын сургуулийн 8 дугаар ангийг, 2005 оноос ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр ангийг өдөр, орой, эчнээ хэлбэр болон албан бус боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр суралцаж, суурь боловсролын гэрчилгээтэй иргэнийг суурь боловсролтой гэж үзэж энэ төвшинд хамруулна. Ерөнхий боловсролын ердийн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, тусгай, олон улсын хөтөлбөрийн сургалттай сургуулийн суурь боловсролын төвшний сургалтын хөтөлбөр хамаарна.
Бүрэн дунд боловсрол
2006 он хүртэл ерөнхий боловсролын сургуулийн 10-р ангийг, 2006-2014 оныг дуустал ерөнхий боловсролын сургуулийн 11 дүгээр ангийг, 2015 оноос ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийг өдөр, орой, эчнээ хэлбэр болон албан бус боловсролын сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын бүрэн дунд боловсрол олгох сургалтад хамрагдаж бүрэн дунд боловсролын үнэмлэхтэй төгссөн иргэнийг бүрэн дунд боловсролтой гэж үзэж энэ төвшинд хамруулна. Ерөнхий боловсролын ердийн, төрөлжсөн, гүнзгийрүүлсэн, тусгай, олон улсын хөтөлбөрийн сургалттай сургууль болон албан

бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын хөтөлбөр хамаарна.

Мэргэжлийн болон техникийн боловсрол

Иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэх тодорхой төвшний ур чадварыг эзэмшүүлэх, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх (Монгол Улсын “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай" хууль 5.1) зорилго бүхий мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, политехникийн коллеж, дээд сургууль, коллежийн мэргэжлийн боловсролын хөтөлбөр мэргэжлийн чадамж эзэмшсэнийг илтгэх диплом, мэргэжлийн үнэмлэх, чадамжийн гэрчилгээ олгодог богино хугацааны сургалтын хөтөлбөрийг хамруулна.

Дипломын боловсрол

Дипломын боловсролд суралцагчид туршлагад суурилсан нарийвчилсан мэргэжил олгож, хөдөлмөрийн зах зээлд ажиллах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэхэд чиглэгдсэн түргэвчилсэн дээд боловсролыг хамруулна. Дипломын боловсролын сургалтын агуулга нь онолын хувийн жин харьцангуй бага, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх тал нь давамгайлсан, цаашид бакалаврын боловсрол эзэмшихээр шилжин суралцах бололцоог хангасан, дээд боловсрол эзэмшүүлэх, 90 багц цагаас доошгүй агуулга судалсан (Монгол Улсын "Дээд боловсролын тухай" хууль 8.7) сургалтын хөтөлбөрийг хамруулна. Мөн дээд боловсролын бусад төвшинд элсэн суралцах боломжийг олгоно.

Бакалавр

Бакалаврын боловсрол нь суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм- хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр төвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ (Монгол Улсын "Дээд боловсролын тухай" хууль 3.1) Дээд боловсролын бакалаврын зэрэг олгох сургалт, өмнөх төвшний сургалтын багц цагийг оролцуулан 120 багц цагаас доошгүй агуулга судалсан (Монгол Улсын "Дээд боловсролын тухай" хууль 8.7) сургалтын хөтөлбөрийг хамруулна. 1993 оноос өмнө дотоод, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын 4 жилийн хугацаанд эзэмшүүлсэн дээд боловсрол олгох хөтөлбөр хамаарна.

Магистр

Дээд боловсролын магистрын зэрэг олгох сургалт, өмнөх төвшний сургалтын багц цагийг оролцуулан 150 багц цагаас доошгүй агуулга судалсан (Монгол Улсын "Дээд боловсролын тухай" хууль 8.7) сургалтын хөтөлбөрийг хамруулна. 1993 оноос өмнө дотоод, гадаадын сургалтын байгууллагын 5-аас доошгүй жилийн хугацаанд эзэмшүүлсэн дээд боловсролын диплом олгох хөтөлбөр хамаарна.

Доктор

Дээд боловсролын докторын зэрэг олгох сургалт, өмнөх төвшний сургалтын багц цагийг оролцуулан 210 багц цагаас доошгүй агуулга судалсан (Монгол Улсын "Дээд боловсролын тухай" хууль 8.7) сургалтын хөтөлбөрийг хамруулна.